

**МОНГОЛ УЛСЫН МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН  
ҮНДЭСНИЙХӨГЖЛИЙНЦОГЦБОДЛОГЫН СЭЛЭНГЭ АЙМАГТ ХАМААРЛТАЙ ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ  
/2010 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/**

2011.03.11

№	Стратегийн зорилт	Заалт	Хэрэгжилт	Хувь
<b>ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ХИЙГЭЭД НИЙГМИЙН ХӨГЖИЛ</b>				
<b>4.1. Ядуурал, ажилгүйдлийг бууруулах бодлого</b>				
1	<b>Нэгдүгээр үе шат (2007-2015 он):</b> Ядууст чиглэсэн, харьцангуй чинээлэг дунд давхаргыг төлөвшүүлэх эдийн засгийн бодлого хэрэгжүүлж, орлогын өсөлтийг хангах замаар ядуурлыг хоёр дахин бууруулна:	1.Эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй нягт уялдуулан ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг 3 хувиас ихгүй байлгах	2009-2010 онд ажил олгогчоос ирүүлсэн нийт 3552 ажлын байранд 3529 хүнийг ажилд зуучлан хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж буй иргэдийн тоо 2010 оны жилийн эцсийн байдлаар 998 болж, эдийн засгийн идэвхтэй хүн амьд харьцуулбал ажилгүйдлийн түвшин 2.5 хувьтай болсон нь өнгөрсөн оныхоос 0.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	100
		2.Ажилгүй, ядуу, нэн ядуу иргэдэд мэргэжил, ажлын дадлага туршлага эзэмшүүлэн, ажлын байртай болгох, хөгжлийн зээл, тусламжид хамруулах зэргээр амьжиргааны эх үүсвэртэй болох, орлогоо нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;	Аймгийн хэмжээнд ядуурлаас гаргах 486 өрхийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж, өрх бүрт “Өрхийн хөгжлийн төлөвлөгөө” хөтлөн хөдөлмөр эрхлэлт халамжийн үйлчилгээ болон бусад төсөл хөтөлбөрт хамруулснаар 306 өрхийн амьжиргааны түвшин дээшилсэн байна. Нийт 1105 ажилгүй иргэдийг мод тарих, тохижилт, малын сэг зэм устгах, хог арилгах зэрэг 58 удаагийн нийтийг хамарсан ажилд хамруулан, 83912.8 мянган төрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцууллаа. Нийтийг хамарсан ажилд хамрагсдын 82 хувь нь орлого багатай иргэд байна. “Ногоон ажлын байр” хөтөлбөрийн хүрээнд 443 иргэнийг ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, хүлэмж, суулгац суулгах ажилд хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 29760.0 мянган төгрөгийг зарцууллаа. “Хүнс тэжээл, нийгмийн халамж”-ийн хөтөлбөрт 885 иргэн хамрагдаж, хүнсний хэрэглээний гол нэрийн бүтээгдэхүүнийг тогтвортой үнээр худалдан авахад зориулж, сар бүр хүнсний талоныг олгож, 9750.0 мянган төгрөгийн санхүүжилтийг хийлээ. Хөтөлбөрт 17 сум, 5 тосгоны 31 дэлгүүртэй гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.	100
		3.Ажлын байр шинээр бий болгосон аж ахуйн нэгж, байгууллагад эдийн засгийн урамшуулал олгох	Шинэ ажлын байрыг бүртгэх <a href="http://www.ejob.mn">www.ejob.mn</a> вэб сайтад сар бүр мэдээ мэдээллийг оруулснаар ажилгүй, ажил хайж байгаа иргэд мэдээллийг дэлгэрэнгүй авах нөхцөл бүрдэж, 2010 оны жилийн эцсээр 2106 шинэ ажлын байр бий болсноос 8.3 хувь нь төсөвт байгууллагад, 91.7 хувь нь хувийн хэвшилд бүртгэгдсэн байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн дагуу 10 сумдын 52 иргэдийг ажлын байртай болгож, 24 аж ахуй нэгж, байгууллагад 35000.0 мянган төгрөгийн урамшуулал олголоо. Ажилгүйдэл ядуурлыг бууруулахад амжилт гаргасан шилдэг сум, аж ахуй нэгж, иргэнийг шалгаруулж, 2010 оны “Шилдэг аж ахуйн нэгж”-ээр Цагааннуур сумын “Баян дулаан-Уул” ХХК, “Шилдэг сум”-аар Мандал сум, “Шилдэг иргэн”-ээр Алтанбулаг сумын иргэн Ц.Башуу, Зүүнбүрэн сумын иргэн Б. Ганзориг нар тус тус шалгарч, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдлаа.	100

**ШИНЭЭР БИЙ БОЛСОН АЖЛЫН БАЙР**

/эдийн засгийн салбараар ангиллаар нь авч үзвэл/



**4.2. Жендэрийн тэгш байдлыг хангах бодлого**

2	<p><b>Бүх үе шат (2007-2021 он)</b> Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг үндэсний соёлын дэвшилтэт уламжлал, хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололттой хослуулан төлөвшүүлнэ</p>	<p>4.Удирдах, шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх.</p>	<p>Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийн аймгийн Засаг даргын захирамжаар байгуулан ажлын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хүрээнд гэр бүлийн гишүүдийн эрхийг хүндэтгэсэн гэр бүлд төвтэй нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх, жендэрийн асуудлаар хүн амын дунд сургалт явуулах, хөтөлбөр, гарын авлага боловсруулж түгээх, ерөнхий боловсролын сургуулийн ахлах анги, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн сургалтын хөтөлбөрт жендэрийн асуудлыг тусгах, гэр бүлийн хүчирхийлэл, хүний эрхийн чиглэлээр мэдээлэл, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Аймгийн Засаг даргын ивээл дор аймгийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг зохион байгуулж, 17 сум, 6 тосгоны 51 байгууллагын 120 төлөөлөгчид чуулж, орон нутгийн хөгжилд эмэгтэйчүүдийн үүрэг, оролцоо, тулгамдсан асуудлыг шийдвэр гаргах түвшний хүмүүст хүргэх, эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, нийгмийн харилцаанд орох эрхийг нь хангах зэрэг асуудлаар хэлэлцлээ.</p>	100
---	--	---	---	-----

**4.3. Гэр бүлийн хөгжил, хүн ам зүйн бодлого**

3	<p><b>Бүх үе шат (2007-2021он)</b> Хүүхэд эхээс төрсөн цагаасаа зургаан нас хүртэл гэр бүл, эсхүл түүнтэй дүйцэх орчинд өсөж торних, зөв хүмүүжил, ёс суртахуунтай болох, сургуулийн өмнөх боловсрол олгоход төрөөс онцгой анхаарна:</p>	<p>5.Хүүхдийг хөхөөр хооллох, зургаан нас хүртэл нь эрүүл мэндийн тусгай хяналтанд байлгах нөхцөл бүрдүүлэх;</p>	<p>“Эх, нярайн өвчлөл эндэгдлийг бууруулахад хамт олны оролцоо,дэмжлэг” сэдэвт олон улсын эмч нарын зөвлөгөөнийг зохион байгуулж, ОХУ, Улаанбаатар хотын ЭНЭШТөв, УКТЭ-ийн, Дархан-Уул аймгийн Анагаах Ухааны Коллежийн төлөөлөл нийт 80 гаруй эмч мэргэжилтэн, төлөөлөгчид оролцлоо. 17 сумдын эмч, эх баригч, сувилагчдыг аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх, эмэгтэйчүүд, дотор, мэдрэл, хүүхдийн тасагт нарийн мэргэжлийн эмч, сувилагчдыг дагалдуулж, нярайд үзүүлэх тусламж үйлчилгээний шинэлэг арга барилд суралцах, нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн замаар дамжин өвчин халдварлахад үзүүлэх тусламж, үйлчилгээний уялдааг сайжруулах замаар төрөлхийн тэмбүүг бууруулах, мэдлэг, чадвар олгох, төслийн тайлан гаргах, мэдээлэх, шинээр оношлогоо, эмчилгээнд хэрэглэгдэж буй тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, түүнийг ашиглах арга</p>	100
---	--	--	--	-----

			<p>барилд сургах зорилгоор “Шинэ санаа” сургалтыг зохион байгуулж, нийт 96 хүнийг хамрууллаа. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх, хүүхдийн тасгийн тоног төхөөрөмжийг сайжруулах ажлын хүрээнд орон нутгийн төсвийн 15.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн эмгэг нярайн тасгийг шинээр нээж, Дэлхийн Зөн Олон Улсын байгууллагын Сэлэнгэ хөгжлийн хөтөлбөрийн газрын 4.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар багаж хэрэгсэл, 19.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тавилга, орон нутгийн төсвийн 7.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар төрөхийн өмнөх тасгийг өвчтний ороор хангасан байна. 2010 оны жилийн эцсийн байдлаар 1896 эх төрж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1000 хүн амд ногдох төрөлт 0.2 промилээр өсч, 1909 амьд хүүхэд төрсөн байна. Нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 16, 1-4 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 8 тохиолдолд тус тус бүртгэгдэж, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1000 амьд төрсөн хүүхэд тутамд 3.7 промилээр буурсан байна.</p>	
		<p>6.Хүүхдийг бие бялдар, эрүүл мэнд, оюун ухаан, сэтгэцийн зөв хөгжилтэй, үндэсний хэл, сэтгэлгээтэй болгон хүмүүжүүлэхэд эцэг, эх, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын байгууллагын үүргийг өндөржүүлэх</p>	<p>Эрүүл аж төрөх, эрүүл мэндээ хамгаалах зан үйлийг төлөвшүүлэн, хүүхэд залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор хүн амд хөдөлгөөний эрүүл мэндийг сурталчлах, ажлын байранд хийх дасгал, хийн дасгал хөдөлгөөний кино бүхий бичлэгийг нийт сумдад тараан, бүх шатны эмнэлгүүдэд “Идэвхтэй хөдөлгөөн-эрүүл аж төрөх ёс” сэдэвт аяныг зохион байгууллаа. “Бие бялдрын түвшин тогтоох сорил” тодорхойлох 8 арга зүйч, 12 сумын ерөнхий боловсролын сургуулийн 28 багшийг сургаж, бие бялдрын түвшин тогтоох сорилд 2243 хүнийг хамрууллаа. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Өсвөр үе залуучуудын цогцолборын “Сайн дурын зөвөлгөө -шинжилгээний төв”-д эрсдэлтэй хүн амд ХДХВ/ДОХ/БЗДХ-аас сэргийлэх “Үе тэнгийн сургагч “бэлтгэх сургалтыг 2 удаа зохион байгуулж, 45 хүнийг сургаж бэлтгэлээ. Сэлэнгэ аймгийг 2021 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүн амын бие бялдрын түвшинг нэмэгдүүлэх ажлын хүрээнд уралдаан тэмцээн, нийтийн биеийн тамирын арга хэмжээний тоо чанарыг өргөжүүлэн 2009-2010 онд хүүхэд багачуудыг спортод татан оролцуулах чиглэлээр чөлөөт бөх, футзалын төрлүүдээр <b>Улсын аварга шалгаруулах тэмцээнийг</b> аймагтаа зохион байгуулж, аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 14 удаа, нэрэмжит тэмцээнийг 15 удаа, нийтийн биеийн тамирын арга хэмжээг 29 удаа зохион байгуулан аймгийн нийт хүн амын 20.4 хувь буюу 24840 хүнийг татан оролцууллаа. 2010 онд аймгийн хэмжээнд 164 секц дугуйланд 2565 гаруй тамирчид хичээллэж, улсын аварга болон тив дэлхийн тэмцээнд 589 тамирчин оролцож, аймаг орон нутгийнхаа нэрийг дуурсган амжилт үзүүлж, авхаалж самбаа авьяас чадвараа дайчлан медалийн болзол хангасан 116 тамирчинд аймгийн Засаг даргын захирамжаар 9960.0 мянган төгрөгийн урамшууллыг олгосон. 2010-2011 оны хичээлийн жилд аймгийн Засаг даргаас 370 ширхэг шатрыг ерөнхий боловсролын 35 сургууль, Хүүхдийн ордонд олгож, Сүхбаатар сумын-1,3, Мандал-1,3, Сайхан, Сант, Түшиг сумд, Дулаанхан тосгоны сургуулиудын шатрын дугуйланд нийт 12 бүлэгт 297 хүүхэд хамрагдсанаар хүүхдийн сэтгэхүйг хөгжүүлэх таатай</p>	100

			боломж бүрдлээ. Хүүхдийн ордны шатрын дугуйланд 7-13 насны 45 хүүхдүүд хамрагдаж, “Цодгор хүү” улсын уралдаанд 7-12 насны 12 хүүхэд оролцож, 1 мөнгө, 2 хүрэл медаль, Ж.Гүррагчаагийн нэрэмжит “Ирээдүйн одод” шатрын тэмцээнд 17 хүүхэд оролцож, багаараа тусгай байранд шалгарсан амжилтыг үзүүлээд байна.	
<b>4.4. Боловсролын хөгжлийн бодлого</b>				
4	<b>Нэгдүгээр үе шат (2007-2015 он)</b> Суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлнэ:	7.Бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамрагдах боломж нөхцөлийг бүрдүүлэх;	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулж, аймгийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлэх, малчид, ногоочид, тариаланчдын хүүхдийг гэр цэцэрлэгт хамруулах зорилгоор явуулын багшийн модулын сургалтыг Сүхбаатар 3,4,7-р баг, Алтанбулаг, Баруунбүрэн, Ерөө, Зүүнбүрэн, Орхонтуул, Сант, Түшиг, Хүдэр, Цагааннуур, Шаамар, Жавхлант сумд, Хэрх, Номгон тосгонд зохион байгуулж, 1500 хүүхдийг хамрууллаа. Сүхбаатар сумын 3-р цэцэрлэг дээр 9 хүүхэдтэй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүлэг хичээллэж, цэцэрлэгүүд дээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тухайн насны бүлэгт хамруулан, хөгжлийн онцлогт нь тохирсон сургалтыг зохион байгуулан ажилласнаар эцэг эхчүүдээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хандах хандлага, сэтгэл зүйд нь өөрчлөлт гарч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төлөвших үйл явцад ахиц гарсан байна. Дэлхийн Зөн Олон Улсын байгууллагын Сэлэнгэ нутгийн хөгжлийн хөтөлбөрийн 4.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Мандал сумын 1, Нархан цэцэрлэгүүдэд иж бүрэн тоног төхөөрөмжтэй эмчийн өрөөг ашиглалтанд орууллаа. Улс, орон нутгийн төсвийн 104.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Мандал сумын 1, Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгт их засварыг хийж, цэцэрлэгүүдийн сургалтын материаллаг баазыг бэхжүүлэн, сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайгаар хангаж, хүүхдийн сурч хөгжих ая тухтай орчинг бүрдүүллээ. Улсын төсөвт 30 цэцэрлэгт 4706, хувийн хэвшлийн 2 цэцэрлэгт 131, сувиллын яслид 35, албан газрын төсөвт цэцэрлэгт 538, хувилбарт сургалтанд 1466, нийтдээ 6876 хүүхэд СӨБ-д хамрагдаж, хамран сургалт <b>96.5</b> хувь, цэцэрлэгийн үндсэн бүлгийн хамран сургалт <b>78.9</b> хувьд хүрч, улсын дундажтай харьцуулахад <b>9.1</b> хувь, үндсэн бүлгийн хамран сургалтыг улсын дундажтай харьцуулахад <b>8.4</b> хувиар ахиж, өмнөх оныхоос <b>13.2</b> хувиар ахиж, дэвшүүлсэн зорилт бүрэн хэрэгжлээ.	100
		8.6 настай хүүхдийг сургуульд бүрэн хамруулах;	Аймгийн хэмжээнд 6 настай хүүхдийн бүртгэл, судалгааг нарийвчлан гаргаж, 1-р ангид элсэх 1824 хүүхдийг сургуульд бүрэн хамруулан, 12 жилийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр хичээллэж, багшаар бүрэн хангалаа. Сургууль бүр 6 настны ангийг стандартын дагуу бүрэн тохижуулж, сургалтын техник, төхөөрөмж, цахим сургалтын материал, багш, сурагчийн ширээ сандал, хичээлийн болон дотуур байрны ариун цэврийн өрөөг улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн газар, өөрсдийн нөөц бололцоонд түшиглэн засварлаж, сургалтын орчинг бүрдүүлэх ажлыг амжилттай хэрэгжүүллээ. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Үр дүнд түргэн хүргэх санаачлагын түншлэл” төслөөс 6 настанд хичээл заах, тэдэнтэй ажиллах арга зүйн сургалтыг зохион байгуулж, 74 багш хамрагдлаа. 2009-	100

		2010 оны хичээлийн жилд 6 настай 1824 хүүхэд 1-р ангид суралцаж байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулбал 470 хүүхдээр нэмэгдсэн байна.	
	9.Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны тохилог орчинг бүрдүүлж, дотуур байранд суух хүүхдийн тоог 2.1 дахин нэмэгдүүлэх;	Дотуур байрны орчин нөхцлийг сайжруулах зорилтын хүрээнд суралцагчдын амьдрах таатай нөхцөл байдлыг бүрдүүлэн, орны тоог нэмэгдүүлснээр малчдын хүүхдийн хамрагдах хүрээ нэмэгдэж, сургууль завсардалт буурахад эерэг нөлөө үзүүлж байна. Дотуур байрны хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг сайжруулах, хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлэх талаар анхаарч, дотуур байрны багш нарын мэргэжлийн ур чадварыг сайжруулан, хариуцлага, санаачлагатай багш мэргэжлийн хүнийг дотуур байрны багшаар томилон ажиллуулж байна. Дотуур байрны хүчин чадлыг нэмэгдүүлэх, орчин нөхцлийг сайжруулах зорилтын хүрээнд улсын төсвийн 300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Зүүнбүрэн суманд 75 хүүхдийн хүчин чадалтай дотуур байрыг барьж ашиглалтанд оруулж, Азийн Хөгжлийн Банкны санхүүжилттэй Боловсролын хөгжлийн хөтөлбөрийн “Үр дүнд түргэн хүрэх санаачлагын түншлэл” төслийн 27.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар сумын 12 жилийн 1 дүгээр сургуульд эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан гал тогооны тоног, төхөөрөмж нийлүүлж, дотуур байрны тохилог орчинг бүрдүүлснээр 2010-2011 оны хичээлийн жилд 1434 хүүхэд дотуур байранд сурч амьдарч, дотуур байрны хамралт <b>91.0</b> хувьтай, үүнээс 959 нь малчдын хүүхэд байна.	100
	10.Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын“ <b>Үдийн цай</b> ” хөтөлбөрийг үргэлжлүүлэх;	“Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилт, ариун цэврийн нөхцөл байдлыг судлан дүгнэлт гаргах ажлын хэсэг 12 сумын сургуулийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцан зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа. Сургууль бүр 7-14 хоногт анги танхим, гал тогоо, ариун цэврийн өрөөнд ариутгал хийж, 2009-2010 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 1-5-р ангийн <b>9602</b> хүүхэд “Үдийн цай” хөтөлбөрт хамрагдаж, <b>601020.3</b> мян төгрөгийн санхүүжилт хийгдлээ. Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу “Үдийн цай” хөтөлбөрийг “Үдийн хоол” хөтөлбөр болгон өргөжүүлэн дунджаар 7 хоногийн 3 өдөрт халуун хоолоор үйлчилж, нийт сургуулиудын <b>88.3</b> хувь нь сургуулийн цайны газраас эрүүл ахуйн шаардлага хангасан, илчлэг сайтай халуун хоол цайгаар үйлчилдэг болсон. Улсын төсвийн <b>20.0</b> сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Орхонтуул сумын 9 жилийн сургуульд гал тогооны засвар хийж, “Үр дүнд түргэн хүрэх санаачлагын түншлэл” төслийн <b>27.0</b> сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар сумын 12 жилийн 1 дүгээр сургуульд эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан гал тогооны тоног, төхөөрөмж нийлүүлж, “Үдийн цай” хөтөлбөр хэрэгжих таатай орчинг бүрдүүллээ.	100
	11.2010 он гэхэд хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшинг 99.0 хувьд хүргэх.	Баруунбүрэн сумын Гэгээрэл төвөөс хийдийн лам хүүхдүүдэд боловсрол нөхөн эзэмшихэд нь туслан дүйцсэн хөтөлбөрийн сургалтандаа жил бүр 20 хүүхдийг хамруулан амжилттай сургаж байна. Хүн амын бичиг үсгийн боловсролын түвшинг дээшлүүлэх чиглэлээр зуны улиралд бичиг үсгийн сургалтуудыг тогтмол явуулж байгаагийн үр дүнд бичиг үсэг үл мэдэгчдийн тоо <b>139</b> болж, өнгөрсөн жилийнхээс <b>39.1</b> хувиар буурч, бичиг үсэг	100

			тайлагдалтын түвшин <b>71.3</b> хувьд хүрсэн байна. Албан бус боловсролын Гэгээрэл төвүүдэд шаардлагатай компьютерийн судалгааг гарган, “Тогтвортой амьжиргаа-2”, Дэлхийн Зөн Олон Улсын Байгууллагын төслөөс Цагааннуур, Алтанбулаг, Баянгол, Мандал, Шаамар, Сүхбаатар сумдын Албан бус боловсролын “Гэгээрэл төв”-үүд иж бүрэн компьютерийн тоног төхөөрөмжөөр хангагдлаа. Албан бус боловсролын Гэгээрэл төвийн багшийг давтан бэлтгэх, чадваржуулах чиглэлээр төвлөрсөн сургалтанд 5, орон нутгийн сургалтанд давхардсан тоогоор 40 багш хамрагдан мэргэжил боловсролоо дээшлүүлэв.	
5	Багшийн мэргэжил, арга зүйн хөгжил болон цалин хөлс, урамшуулал, нийгмийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, энэ чиглэлдхөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлнэ:	12.Багш, боловсролын байгууллагын удирдах ажилтны ур чадварыг хөгжүүлж, ажлын чанар, хөдөлмөрийн үр бүтээлийг үнэлэх шалгууруудыг зөв тогтоож, цалин хөлс нэмэгдүүлэх, урамшуулал олгох зэргээр нийгмийн хамгааллыг сайжруулах;	Улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр, өөрсдийн нөөц боломжинд тулгуурлан цэцэрлэгийн 91 хувь, ерөнхий боловсролын сургуулийн 94.2 хувь нь “Багш хөгжлийн төв”-тэй болж, багш нарын дунд сургалт семинар, сурган хүмүүжүүлэх уншлага, ур чадварын уралдаан, үзүүлэх ажил, олимпиад, спорт, урлагийн уралдаан, тэмцээнийг хамтран зохион байгуулах ажлыг тогтмолжуулснаар бүсийн сургууль, цэцэрлэгүүдийн багш нар ажлын байрандаа тасралтгүй мэргэжлээ дээшлүүлэх, харилцан туршлага солилцох, боловсролоо дээшлүүлэх боломж бүрдсэн. 1, 5,10 дахь жилдээ ажиллаж байгаа багш нар 7, 14, 21 хоногийн хугацаатай 3 удаагийн мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдах болсон нь багш бүрт арга зүй, ур чадвараа дээшлүүлэх тэгш боломж бүрдэж, сургуулийн хөгжилд ахиц гарч, сургалтын чанарт сайнаар нөлөөлж байна. Аймгийн хэмжээнд төвлөрсөн сургалтанд 338, төрөлжсөн сургалтанд давхардсан тоогоор 2541 багш, удирдах ажилтнууд мэргэжил боловсролоо дээшүүлснээр боловсролын стандартыг хэрэгжүүлэх, сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүйд ахиц гарч байна. <b>2010 онд Баянгол сумын 12 жилийн дунд сургууль, Мандал сумын “Нархан” цэцэрлэг нь улсын тэргүүний сургууль, цэцэрлэгээр шалгарсан амжилтыг үзүүллээ.</b> Боловсролын тухай хуулийн дагуу сургууль цэцэрлэгийн өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 45 багш ажилчдад <b>142015.4</b> мянган төгрөг, сургууль цэцэрлэгийн 55 багш ажилчдад 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжинд <b>75754.8</b> мянган төгрөг, Засгийн Газрын тогтоолын дагуу улирал тутмын үр дүнгийн урамшууллыг сургууль цэцэрлэгийн 2021 багш, ажилчдад урамшил цалин <b>601020.3</b> мянган төгрөгийг тус тус олгож, хөдөлмөрийн бүтээмж, нийгмийн хамгааллыг сайжрууллаа.	100
6	Иргэд боловсролоо сайжруулж, ажил мэргэжлээрээ хөрвөн суралцаж байх бодит боломж олгосон боловсролын нээлттэйагуулга, уян хатан арга хэлбэрийг бий болгож хэрэгжүүлнэ:	13.Техникийн боловсрол, мэргэжлийн сургалт, дээд боловсролын чанар ба хамран сургалтын төлөвлөлт, зохицуулалтыг сайжруулах;	Мандал, Сүхбаатар, Шаамар, Сант сумын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэж, бүрэн дунд боловсролыг олгож байна. Авто жолоо, авто машины засвар, трактор, үсчин, гоо засалч, барилгын гэр ахуй, модон эдлэл мужаан, хоол үйлдвэрлэл, талх, нарийн боов, оёдол, эсгүүр, чимэглэл зураг, барилгын өргөн мэргэжил, барилгын засал чимэглэл, барилгын сантехник, засвар, гагнуур, компьютер засвар, мал аж ахуйн фермер жолооч, газар тариалан фермер, жолооч, хүнд даацын авто машин, ня-бо мэдээлэл зүй, автомеханик, агро ферм, жолоо засвар ашиглалт, зөгийн аж ахуй, цахилгаан	100

			хийн гануур зэрэг 34 мэргэжлүүдээр элсэлт авч, 2009-2010 хичээлийн жилд Сүхбаатар, Шаамар, Сант, Мандал суман дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд нийт 34 мэргэжлээр 723 суралцагч суралцаж төгссөн байна. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн сургалтын 38 лаборатори, 28 дадлагын ажлын өрөөний суудлын тоо 950 болж, сургалт дадлагын орчин сайжирч, үйлчилгээний хүрээ өргөжсөн байна. 2009-2010 оны хичээлийн жилд Мандал сумын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд улс, орон нутгийн болон гадаад дотоодын 172.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс Бороо-Гоулд ХХК-ны 4.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар барилгын сантехникийн иж бүрэн засвар, орон нутгийн төсвийн 9.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гаднах тохижилт хийгдэж, БНСУ-ын И-Сон сумын 47.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 165 м <sup>2</sup> талбай бүхий 3 хүлэмж шинээр байгуулж, газар тариалан, фермерийн мэргэжлийн ангийн оюутнууд дадлага ажил хийх боломж бүрдсэн байна. Сүхбаатар сумын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд “Өвсний үндэс” хөтөлбөрийн 70.0 мянган долларын хөрөнгө оруулалтаар барилгын засвар хийгдсэн. Шаамар сумын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд Турк Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн шугамаар 11.0 мянган долларын хөрөнгө оруулалтаар биеийн тамирын сургалтын тоног төхөөрөмж, хэрэгсэл, Дэлхийн Зөн Олон Улсын байгууллагын Сэлэнгэ Хөгжлийн хөтөлбөрийн 3.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар зөгийн аж ахуйн кабинетыг шинээр байгуулж, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам, Олон улсын Каталитик сантай хамтран хэрэгжүүлж буй “Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачилгын түншлэл” хөтөлбөрийн 50.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хичээлийн 3 анги, дотуур байрны иж бүрэн засвар, сургуулийн дээврийн засвар, Сант сумын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 1.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 8 ангийг багш, сурагчийн ширээ сандлаар бүрэн хангалаа.	
7	Сургууль төвтэй менежментийг хөгжүүлж, сургалтын байгууллагын бүтэц, хэв шинж, байршлын зураглалыг шинэчлэн зохионо.	14.Боловсролын салбарын захиргааны болон мэргэжлийн удирдлагыг боловсронгуй болгох;	Боловсролын байгууллагуудын удирдлагуудад ажлын байрны сул орон тоо гарсан тохиолдолд нээлттэй өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулалтын зарчмаар ажилд томилох бодлогыг баримтлан ажиллаж, 2009-2010 оны хичээлийн жилд 11 цэцэрлэг, 2 сургуулийн захирлын албан тушаалын ажлын байранд сонгон шалгаруулалтыг зохион байгууллаа. Сумдын дарга нар ерөнхий менежерүүдтэй бүтээгдэхүүн нийлүүлэх, санхүүжилт авах гэрээг жил бүр байгуулан хагас, бүтэн жилээр хяналт шинжилгээ хийж, үр дүнгийн гэрээний үнэлгээгээр хангалттай дүгнэгдсэн ерөнхий менежерүүдэд зохих журмын дагуу урамшуулах ажлыг тогтмолжуулсан.	100
<b>4.5. Эрүүл мэндийн хөгжлийн бодлого</b>				
8	<b>Нэгдүгээр үе шат (2007-2015 он)</b> Сум, өрхийн эмнэлгийн анхан шатны тусламж хүргэх, шинжилгээ,	15.Шүд эмчлэх, эрхтэн тогтолцооны өвчний оношилгоо, эмчилгээний арга технологийг сумын түвшинд нэвтрүүлэх;	Явуулын амбулаторийн үзлэгээр 7 сумын 441 иргэд, малчдад нарийн мэргэжлийн нүүр, амны хөндийн эмчийн тусламжийг үзүүлж, “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээний үеэр 11 сумын 443 хүнд шүд амны хөндийн тусламж үзүүлж, шүд эрүү нүүр, төрөлхийн уруул тагнай сэтэрхий 21 хүнийг хяналтанд авч эрүүлжүүллээ. Ерөө, Орхон суманд зохион байгуулсан “Эрүүл	100

	оношилгоо, эмчилгээ, дархлаажуулалт хийх, шүдний өвчин эмчлэх, бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдол, сүрьеэгээс сэргийлэх, эх, нялхсын эрүүл мэндийг хамгаалах чадамжийг цогц байдлаар хөгжүүлнэ;		мэндийн өдөрлөг"-ийн үеэр 152 хүнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, нийт 785 иргэдэд шүд амны хөндийн эрүүл мэндийг хэрхэн сахих талаар зөвлөгөө өгч, 2 төрлийн 560ш санамж, зөвлөмж тараасан байна. Аймгийн "Нээлттэй хаалганы өдөр" арга хэмжээний үеэр 17 сум, 6 тосгоны иргэдэд явуулын үйлчилгээгээр эрүүл мэндийн сургалт сурталчилгаа зохион байгуулж, 6096 хүнийг үзлэг, оношлогоонд хамрууллаа.	
		16.Малчдад нүүдлийн өрхий эмнэлгээр үйлчлэх тогтолцоог бүрдүүлэх;	Алслагдсан нутгийн хүн ам, малчид, тариаланчид, залуучууд, захын хорооллын оршин суугчид, эмзэг бүлгийхэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэх зорилгоор явуулын амбулаторийн үйлчилгээг үзүүлэх ажлыг 17 сум, 6 тосгонд 20 нарийн мэргэжлийн их эмч нар 2 багт хуваагдан тусламж үйлчилгээг үзүүллээ. Үзлэгт 3347 өрхийн 8669 хүн хамрагдсанаас 3483 эрүүл, 4915 хүнд эмчилгээний зөвлөмж өгч, 103 хүнийг диспансерийн хяналтанд авч, 20 нэр төрлийн 23497 ширхэг сурталчилгааны материал тараан, 12 төрлийн 4.2 сая төгрөгийн эм тариагаар үйлчиллээ.	100
9	Аймаг, дүүргийн болон улсын клиникийн нэгдсэн эмнэлэг, мэргэжлийн төвүүдийн үйл ажиллагааны чадамжийг хөгжүүлнэ;	17.Алсын зайны оношилгоо, эмчилгээний аргуудыг эмнэлэгт нэвтрүүлэх;	Эрүүл Мэндийн Яамны хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлгийг иж бүрэн 15ш компьютероор хангаж, ЭМЯ-тай холбогдох программын холболт хийж цахим хэлбэрээр мэдээлэл солилцох бүрэн боломж бүрдлээ. 17 сум 4 тосгоны эмнэлэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зайны оношлогооны цахим нэгдсэн сүлжээг ашигладаг болсноор Эрүүл Мэндийн Яамнаас шинэ мэдээ мэдээллийг шуурхай авч, солилцох, мэргэжилтнүүд болон эмч нар ажлын байрандаа суралцах нөхцөл бүрдлээ. Аймгийн Нэгдсэн Эмнэлэг нь Зүрх судас, эх нярайн зайн оношлогооны кабинетууд ЭНЭШТөв, болон клиникийн нэгдсэн 3-р эмнэлэгт нийт 24 удаа дамжуулалт хийн зөвлөгөө авч ажилласан. Зүрх судасны алсын зайн оношлогооны кабинет нь сумдын эмнэлгүүдтэй 15 удаа холбогдож, зүрх судасны эмгэгийн талаарх зөвлөгөө өгч, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.	100
		18.Өвчний түүхийг цахим картын тогтолцоон доруулах	Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь өөрсдийн нөөц бололцоог ашиглан Дүн бүртгэлийн тасаг ажиллуулан өвчтөний түүхийг цахим картанд оруулах боломж нөхцлийг судлах, холбогдох байгууллагуудад хамтран ажиллах санал тавих, шаардлагатай тоног, төхөөрөмж, программын судалгааг хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэж, цахим картын тогтолцоонд шилжих ажлыг эхлүүлээд байна.	30
10	Эрүүл мэндийн байгууллагыг мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай боловсон хүчнээр хангана;	19.Эрүүл мэндийн байгууллагыг үйлчлүүлэгчээ дээдэлсэн үйл ажиллагааны зарчимтай болгох;	"Үйлчлүүлэгчдэд ээлтэй тусламж" үзүүлэх зорилгоор 2 дахь шатлалын эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгийг сум, өрх, албан байгууллагын хүн амын дунд зонхилон тохиолдох өвчин эмгэгийг илрүүлэх, эмчлэх ажлыг эрүүл мэндийн "Нээлттэй хаалга"-ны өдөр хэлбэрээр зохион байгуулж, эрүүл мэндийн сургалт сурталчилгааг хийж, гарын авлага тараалаа. Томуугийн А хүрээний Н1N1 шинэ вирусын халдварын дэгдэлт гарсантай холбогдуулан 0-5 насны хүүхэд, жирэмсэн эх, уушигны архаг өвчтэй, архаг сахарын диабеттай хүмүүсийг эмч, дунд мэргэжилтнүүдэд хуваарилан хариуцуулж, гэрийн идэвхтэй эргэлт, хяналтыг сайжруулах, ард иргэдэд өгөх зөвлөгөө, сурталчилгааг чанаржуулах ажлыг зохион байгуулж,	100



			“Эрүүл эхээс эрүүл хүүхэд” зарчмыг эмнэлгүүд шат шатандаа хэрэгжүүлэхийн тулд эмэгтэйчүүдийн эрхтэн тогтолцооны өвчлөлийг багасгах, урьдчилан сэргийлэх үзлэгийн ач холбогдлыг өргөн сурталчлан ажиллалаа.	
		20.Эмч мэргэжилтнүүдийн цалин, шагнал, урамшуулал, нэмэгдлүүдийн боловсронгуй тогтолцоог хэрэгжүүлэх.	Эрүүл мэндийн салбарт 5724970.6 мянган төгрөгийг зарцуулснаас эмч мэргэжилтнүүдийн цалинд 3026434.7 мянган төгрөг, шагнал урамшуулалд 3500.0 мян төгрөг, тэтгэмжинд 93981.9 мян төгрөгийг тус тус зарцуулсан байна. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаар “Эрүүл мэндийн салбарыг хүний нөөцөөр хангах тухай” асуудлыг хэлэлцүүлэн шийдвэр гаргуулснаар аймгийн Нэгдсэн эмнэлэгт эмэгтэйчүүдийн болон зүрх судасны эмч, Жавхлант, Баруунбүрэн, Орхон, Хушаат сумд, Дулаанхан тосгоны эмнэлгүүдийг их эмчээр хангаж, тус бүрт 1.0-1.5 сая төгрөгийн урамшуулал олгон гэрээ байгуулан ажиллаж, сум, тосгон, сум дундын эмнэлэгт 3-аас дээш жил тогтвор суурьшилтай ажилласан 20 их эмчид албан тушаалын 1 сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал, мөн эмнэлгийн мэргэжилтэнд 5 жил тутам олгодог тэтгэлэгт 36 их эмч, 201 дунд мэргэжилтэнг хамруулан 262.0 сая төгрөгийг зарцуулж, эмч нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах боломжийг бүрдүүлэн бүх сумдыг их эмчээр хангалаа.	100
11	Хүн амын өвчлөл, цаг бусын нас баралтыг бууруулж, дундаж наслалтыг ахиулна. Эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйлийг төлөвшүүлнэ:	21.Хүн амдамьдралын зөв зохистой хэвшил, бие бялдраа чийрэгжүүлэх орчин бүрдүүлэх;	Аж ахуй нэгж байгууллага, ард иргэдэд ажлын байранд хийх дасгал, хийн дасгал хөдөлгөөний хичээлийн бичлэгийг нийт сумдад тарааж, бүх шатны эмнэлгүүдэд “Идэвхтэй хөдөлгөөн-эрүүл аж төрөх ёс” сэдэвт нэг сарын аяны ажлыг зохион байгууллаа. Аяны хүрээнд зарим сумдын эмнэлгүүд чийрэгжүүлэлтийн кабинетыг тохижуулах ажлыг өрнүүлж, Хүдэр, Номгон, Сант, Түшиг сумдад шинэ тоног төхөөрөмжийг суурилуулан тохижууллаа. Монгол Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд биеийн тамир спортод нийтийг хамруулах, насны ангилал бүрд хүн амын бие бялдрын түвшинг тогтоон ахиулах зорилго чиглэлийг баримтлан сумдад орчин үеийн шаардлагад нийцсэн спортын барилга байгууламжуудыг барьж эхлээд байна. 2009 онд Ерөө суманд спортын цогцолборын барилгыг ашиглалтанд оруулж, чийрэгжүүлэх танхим, ширээний теннис, бильярд, сагсан бөмбөг, волейбол зэрэг спортын төрлүүдийн дугуйланд 200 хүүхэд залуусыг хамруулж, орчин үеийн спортын болон үндэсний спорт тэмдэглэлт ойн 12 арга хэмжээ, аймгийн чанартай 2 уралдаан тэмцээнийг зохион байгуулан тус сумын 1670 гаруй хүмүүсийг нийтийн биеийн тамир спортын арга хэмжээнд хамруулсан байна. Мөн Мандал суманд 500 хүний суудалтай спортын цогцолборыг барьж, ашиглалтанд оруулснаар орон нутгийн иргэдийг биеийн тамираар хичээллэх орчин нөхцлийг бүрдүүлж өглөө. Аймаг, орон нутгийн төсвийн 986.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Мандал сумын Түнхэл тосгонд соёл, спортын төв, орон нутгийн төсвийн 460.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн баяр наадмын талбайг орчин үеийн шаардлагад нийцсэн цэнгэлдэх хүрээлэн болгон шинээр барьж эхлээд байна.	100

		<p>22.Хүн амын дунд эрүүл аж төрөх, уур амьсгалын дарамт, удамшлын аливаа доголдлоос эрүүл мэндээ хамгаалахад чиглэсэн сургалт, сурталчилгаа өргөжүүлэх</p>	<p>Орон нутгийн “Шинэ гэгээ”, “Сэлэнгийн мэдээ” сонин, “Миний Монгол” “Таны сэлэнгэ” “Сэлэнгэ-ТВ” КТВ-ээр эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа, нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөөг цувралаар нэвтрүүлж, 3600 гаруй хүнд эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх, зөв зохистой хооллолт, архи, тамхины хор уршиг, дасгал, хөдөлгөөний ач тус, сэтгэцийн эрүүл мэнд, цусны даралт ихдэх өвчин, чихрийн шижин, хавдраас сэргийлье зэрэг сэдвээр сургалт, сурталчилгаа хийж, 24 төрлийн 6800 ширхэг санамж, гарын авлага, зөвлөмж, ном, зурагт хуудас тараан, 10 төрлийн видео кино үзүүлж, сурталчиллаа. Сүрьеэтэй тэмцэх хөтөлбөр, орон нутагт суурилсан сүрьеэгийн төслийн хүрээнд “Дэлхийн сүрьеэтэй тэмцэх өдөр”-ийг угтан сарын аяныг зарлаж, сургуулиудын дунд “Сүрьеэгүй ирээдүйн зүгт хамтдаа” сэдэвт “Дэвжээ” тэмцээн, гар зургийн уралдаан, “Атга будаа, ширхэг төмс”-ний аян өрнүүлж, амжилттай оролцсон сургуулиудыг шагнаж урамшууллаа. Сүхбаатар өртөөнөөс Мандал, Түнхэлийн чиглэлд эмнэлгийн 20 мэргэжилтний бүрэлдэхүүнтэй 2 баг, Сүхбаатар өртөөн дээр 40 хүний бүрэлдэхүүнтэй сурталчилгааны баг ажиллаж, сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх 100ш зурагт хуудас, 1200ш гарын авлагыг зорчин явагчид, өртөөгөөр үйлчлүүлэгчдэд тарааж, сурталчилгаа хийлээ. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн “Сайн дурын зөвлөгөө, шинжилгээний төв”-д эрсдэлтэй хүн амыг ДОХ/ХДХВ/БЗДХ-аас сэргийлэх “Үе тэнгийн сургагч” бэлтгэх сургалтыг 2 удаа зохион байгуулж, 45 хүнийг сургаж бэлтгэлээ. Сүхбаатар сумын Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төв, Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны Сангийн Сэлэнгэ аймаг дахь Алтанбулаг төсөл, Хүүхдийн Төлөө Хэлтэстэй хамтран “Хамтдаа сэргийлцгээе” уриан дор өсвөр үе залуучуудад ДОХ/БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэг олгох зорилгоор өдөрлөг зохион байгуулж 2000 гаруй иргэд хамрагдлаа. Аймгийн Улаан Загалмайн Хороотой хамтран Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 6 сургуулийн 18 сурагчийг ДОХ/БЗДХ-аас сэргийлэх мэдлэг олгох “Үе тэнгийн сургагч бэлтгэх” 3 өдрийн сургалтанд хамруулж, сургагч багш нар нийт 108 сурагчдад сургалт зохион байгуулсан байна. Халдварт Өвчин Судлалын Үндэсний төвийн ХДХВ/ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны багийнхан “100 хувь бэлгэвч хөтөлбөр”-ийн хэрэгжилтэнд хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цагдаагийн байгууллага, шийдвэр гаргах түвшний хүмүүс, бар, зочид буудлын эздэд “100 хувь бэлгэвч хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бидний оролцоо” сэдэвт сургалтыг зохион байгуулж, төрийн захиргаа, хүчний, хувийн хэвшлийн байгууллагын 60 хүнийг хамрууллаа. “ХДХВ/ДОХ/БЗДХ-өвчнөөс урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт сургалтанд Сүхбаатар төмөр зам өртөөний хамгаалах салааны 12 ажилчид, цагдаагийн газрын 27 ажилтан ажиллагсдыг хамрууллаа. Гар, хөл, амны өвчин, гэдэсний халдварт шар өвчний дэгдэлт, халдвараас сэргийлэх ажлын хүрээнд ард иргэдэд хандсан зөвлөмжийг орон нутгийн телевизээр 7 хоногт 5 удаа нэвтрүүлж, сэрэмжлүүлэг бүхий санамжийг гудамж, худаг, хүнс, барааны зах, дэлгүүрээр тарааж, сум, өрхийн эмч нарт арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг суманд нь</p>	<p>100</p>
--	--	---	--	------------

			<p>зохион байгуулж, гэрийн идэвхтэй эргэлт, хяналтыг сайжруулах, ард иргэдэд өгөх зөвлөгөө, сурталчилгааг чанаржуулах ажлыг зохион байгууллаа.</p>	
		<p>23.Нөхөн сэргээх, асаргаа, сувилгааны төрлүүдийг хөгжүүлэх;</p>	<p>“Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй өрх, сумын эмнэлэг” шалгаруулах болзолт уралдааныг өрхийн болон сумдын эмнэлгүүдийн дунд зарлаж, болзолт уралдаанд Сүхбаатар сумын “<b>Хаданхүй</b>” өрхийн эмнэлэг <b>аймаг, улсад тэргүүлж</b>, ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор “Ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ” сэдэвт сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж, сайн дурын 25 идэвхтэнг хамруулж сургагч багш болгон бэлтгэсэн. Сүхбаатар суманд ахмад болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сувилах “Буман нарс” зуны эмчилгээний сувиллыг ажиллуулж, 2009-2010 онд нийт 713 ахмадыг амрааж, бариа засал, зүү төөнүүр шарлага, эмчилгээний дасгал хөдөлгөөн, шавар эмчилгээ, бумба зэрэг эмийн бус эмчилгээг хийж, тэдний чөлөөт цагийг хөгжилтэй үр бүтээлтэй өнгөрүүлэх зорилгоор биеийн тамир, соёл урлагийн зэрэг арга хэмжээг тогтмол зохион байгууллаа. 2010 оны “Нээлттэй хаалганы өдөр”-өөр 17 сум, 6 тосгоны 88 настанд гэрийн асаргаа сувилгааг үзүүлж, “Ахмад настанд үзүүлэх нийгмийн халамж үйлчилгээ”, “Настны эрүүл мэнд-ээлтэй орчин” сэдэвт гарын авлагуудыг нийт 680 ш тарааж, урьдчилан сэргийлэх үзлэгт 2800-аад ахмад настанг хамруулсан байна. Геронтологийн төвийн эмч мэргэжилтнүүдтэй хамтран “Настанд зонхилон тохиолдох яс булчингийн тогтолцооны эмгэгүүд”, “Настанд тохиолдох сэтгэцийн эмгэгүүд” сэдэвт сургалтуудыг зохион байгуулж, 48 эмч, мэргэжилтэн, 26 ахмад настанг хамрууллаа. Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдээс бүрдсэн баг Сүхбаатар сумын хэвтрийн 56 ахмад настанд гэрээр өдрийн эмчилгээ, сувилахуйн тусламж нөхөн сэргээх эмчилгээ хийж, витаминжуулж, биеийн дархлааг сэргээх цэгэн иллэг массаж хийж, асрамжлагч 112 хүнд асаргаа сувилгаа хийх арга аргачлалыг биечлэн заан сургаж, 5 төрлийн зөвлөмж тараан ажиллалаа. 17 сум 6 тосгоны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст “Эрүүл мэндийн төлөө хамтдаа” сэдэвт өдөрлөгийн үйл ажиллагааг зохион байгуулж, лабораторийн 68 шинжилгээ хийж, 3 төрлийн кино гарган, 450 ширхэг эрүүл мэндийн сурталчилгаа тараан, 1112 хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүллээ. Улсын хэмжээнд зарласан “<b>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ээлтэй эмнэлэг</b>” шалгаруулах болзолт уралдаанд <b>аймгийн Нэгдсэн эмнэлэг тэргүүн байр эзэлж</b> цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдав. Италийн АИФО төрийн бус байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчийн газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэм хамт олонд тулгуурлан сэргээн засах “Тэгш дүүрэн” хөтөлбөрийн хүрээнд <b>2.7</b> сая төгрөгийн үнэ бүхий сургалтын болон ортопедийн цехийн тоног төхөөрөмжөөр хангалаа. Улсын төсвийн <b>350.0</b> сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар суманд <b>ахмадын сувиллыг</b> шинээр барьж ашиглалтанд оруулснаар ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ая тухтай амрах, сувилуулах таатай боломж бүрдлээ.</p>	<p>100</p>

		24.Уламжлалт анагаах ухааны шилдэг аргыг эрүүл мэндийн үйлчилгээнд нэвтрүүлэх;	Мандал, Түшиг, Хушаат сум, Бугант, Дулаанхан тосгонд эмийн бус эмчилгээний аргуудыг өргөн хэрэглэж уламжлалт эмчилгээний эмч ажилладаг боллоо. Баянгол сумын амбулаторт хөдөлгөөний иж бүрдэл хэрэгсэл аппаратаар тоноглогдсон кабинет байгуулж, эмийн бус эмчилгээний тусгай сувилал байгуулан ажиллуулж байна. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмийн бус эмчилгээний хэсгийг өргөжүүлж, хөдөлгөөн эвслийн зориулалтын тоног, төхөөрөмжөөр тоноглогдсон кабинет нээн, эмийн бус эмчилгээний 8 ортой бие даасан тасаг байгуулан ажиллаж, үйл ажиллагаа нь жигдрээд байна. Монголын уламжлалт анагаах ухааныг европ эмчилгээтэй зөв хослуулах зорилгоор уламжлалт эмчилгээний чиглэлээр 5 мэргэжилтэнг бэлтгэн ажиллуулж байна. “Тогтвортой амьжиргаа-2” төслөөс Сайхан сумын Номгон тосгоны эмнэлэг 4.7 сая төгрөгний эмийн бус эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангагдсан.	100
		25.Эрүүл мэндийн салбарт хувийн хэвшлийн үйл ажиллагааг өргөжүүлэх;	Аймгийн хэмжээнд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаас амбулаторийн тусламж үйлчилгээ үзүүлдэг 7 үүдэн эмнэлэг, 85 ор бүхий 6 эмнэлэг үйл ажиллагаа явуулж байна. Хувийн хэвшлийн эмэгтэйчүүдийн чиглэлээр “Энэрэлт үйлс”, “Анар”, “Зул” эмнэлэг, хүүхдийн өвчлөлийн чиглэлээр “Тана” эмнэлэг аймгийн нэгдсэн эмнэлэг, Мандал сумын нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажиллаж, улсын эмнэлгийн ачааллыг хөнгөлөхөд дэмжлэг үзүүлж байна. Хувийн хэвшлийн эмнэлгүүд магадлан итгэмжлэлийн шинжээчдийн шалгалтанд орж, 70-82 хувьтай шалгагдсан нь улсын эмнэлгүүдтэй өрсөлдөх түвшинд хүрснийг харуулж байна.	100
		26.Олон нийтийн оролцоо, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах замаар хувь хүн, хамт олон эрүүл мэндээ хамгаалах санал, санаачилгыг дэмжин өрнүүлэх;	“Эх, нярайн өвчлөл эндэгдлийг бууруулахад хамт олны оролцоо, дэмжлэг” сэдэвт олон улсын эмч нарын зөвлөгөөнийг зохион байгуулж, ОХУ, Улаанбаатар хотын ЭНЭШТөв, УКТЭ-ийн, Дархан-Уул аймгийн Анагаах Ухааны Коллежийн төлөөлөл нийт 80 гаруй эмч мэргэжилтэн, төлөөлөгчид оролцлоо. 17 сумдын эмч, эх баригч, сувилагчдыг аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх, эмэгтэйчүүд, дотор, мэдрэл, хүүхдийн тасагт нарийн мэргэжлийн эмч, сувилагчдыг дагалдуулж, нярайд үзүүлэх тусламж үйлчилгээний шинэлэг арга барилд суралцах, нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн замаар дамжин өвчин халдварлахад үзүүлэх тусламж, үйлчилгээний уялдааг сайжруулах замаар төрөлхийн тэмбүүг бууруулах, мэдлэг, чадвар олгох, төслийн тайлан гаргах, мэдээлэх, шинээр оношлогоо, эмчилгээнд хэрэглэгдэж буй тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, түүнийг ашиглах арга барилд сургах зорилгоор “Шинэ санаа” сургалтыг зохион байгуулж, нийт 96 хүнийг хамрууллаа. Аймгийн Улаан Загалмайн Хороотой хамтран Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 6 сургуулийн 18 сурагчийг ДОХ/БЗДХ-аас сэргийлэх мэдлэг олгох “Үе тэнгийн сургагч бэлтгэх” 3 өдрийн сургалтанд хамруулж, сургагч багш нар нийт 108 сурагчдад сургалт зохион байгуулсан байна. Халдварт Өвчин Судлалын Үндэсний төвийн ХДХВ/ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны багийнхан “100 хувь бэлгэвч хөтөлбөр”-ийн хэрэгжилтэнд хөндлөнгийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, цагдаагийн байгууллага, шийдвэр гаргах түвшний хүмүүс, бар, зочид буудлын эздэд “100	100

			хувь бэлгэвч хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бидний оролцоо” сэдэвт сургалтыг зохион байгуулж, төрийн захиргаа, хүчний, хувийн хэвшлийн байгууллагын 60 хүнийг хамрууллаа. “ХДХВ/ДОХ/БЗДХ-өвчнөөс урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт сургалтанд Сүхбаатар төмөр зам өртөөний хамгаалах салааны 12 ажилчид, цагдаагийн газрын 27 ажилтан ажиллагсдыг хамрууллаа.	
		27.Сум, дүүрэг, хот суурин газар болон гэр бүл, ажлын байранд эрүүл мэндийг дэмжих орчныг бүрдүүлэх;	Монгол Улсын Эрүүл Мэндийн сайдын тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”-ыг шалгаруулах болзол, ажлын төлөвлөгөөг бүх сумдад хүргүүлж, өөрсдийн нөөц боломжинд тулгуурлан аймгийн Засаг даргын Тамгын газар, Хилийн цэргийн 0101, 243-р ангиуд, Хилийн Мэргэжлийн Хяналтын газар, Хар луу ХХК нь бие бялдарыг чийрэгжүүлэх танхимыг шинээр нээн ашиглалтанд орууллаа. Сургууль цэцэрлэгүүдэд эрүүл мэндийн хичээлийн кабинет ажиллуулж, “Идэвхтэй хөдөлгөөн-Эрүүл аж төрөх ёс” нэг сарын аяны хүрээнд зарим сумын эмнэлгүүдийн чийрэгжүүлэлтийн кабинетыг тохижуулах ажлыг өрнүүлж, Сайхан сумын “Цемент шохой” ХХКомпани өөрийн хөрөнгө оруулалтаар иж бүрэн хөл бөмбөг, сагсан бөмбөг, волейболын задгай талбайг тохижуулж, ажлын байранд эрүүл мэндийг дэмжих орчныг бүрдүүллээ.	100
		28.Хүн амыг баталгаат ундны усаар хангах, эрүүл ахуйг сайжруулах, химийн болон бусад үйлдвэр, ахуйн хог хаягдлын менежментийг багтаасан амьдралын эрүүл орчин бий болгох замаар эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх.	Аймгийн хэмжээнд ундны усны чанар, аюулгүй байдал, ахуйн хог хаягдлын байдалд лабораторийн шинжилгээ хийж, мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулан илэрсэн зөрчлийг арилгуулахад захиргааны хяналт тавин ажиллаж байна.	90
12	Хүн амыг аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр ханган эрүүл мэндийн шаардлагатай, зохистой технологийг нэвтрүүлж, салбарын дэд бүтцийг сайжруулна:	29.Хүн амыг зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр жигд, хүртээмжтэй, тасралтгүй хангах;	Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын нэгдсэн эмнэлэг, Сайхан сум дундын эмнэлгүүдийн 2010 онд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн тендерт 13 эм ханган нийлүүлэх байгууллага оролцож, 237142.6 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийг тендерээр худалдан авахаар гэрээ хийгдэж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллалаа. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг эмийн сангуудын стандартын хэрэгжилтэнд Мэргэжлийн хяналтын газартай хамтран хөндлөнгийн хяналт тавьж, илэрсэн зөрчлийг цаг тухайд арилгуулах арга хэмжээг авч ажилласан. Улсын мэргэжлийн хяналтын газраас зарласан “Эмийн чанар, аюулгүй байдал” сарын аяны хүрээнд эмийн сангуудын улсын бүртгэлд бүртгэгдсэн эм, эмийн шинжилгээний бичиг, эмийн хадгалалт, эмийг жороор олгож байгаа байдал, эмийн санд мөрдөгдөх анхан шатны бүртгэлийн хөтлөлт зэргийг шалган, зөвлөмж өгч ажиллалаа. Эрүүл мэндийн даатгалын сангаас зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх эмээр үйлчлэх эмийн сангуудыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгууллаа. Хөнгөлөлттэй жороор олгох эмийн сангийн сонгон шалгаруулалтанд 18 эмийн эргэлтийн сан болон салбарын эрхлэгч, багийн	100

			бага эмч нар хамрагдаж, 7 өрхийн эмнэлэг, 89 их, бага эмч нарт хөнгөлөлттэй эмийн жор бичих эрх олголоо Бүх шатны эмнэлгүүдийн хэрэглэж байгаа эм хэрэгслэлд судалгаа хийж, тайланг сар бүр нэгтгэж дүгнэлт хийн ажилласны үр дүнд эмнэлгүүдийн хэрэглэж байгаа зайлшгүй шаардлагатай эмийн хангалт <b>90</b> хувьд хүрлээ.	
		30.Хүн ам, эрүүл мэндийн байгууллагад эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх;	Эмийн сангуудын үйлчилгээний заал, эмч нарын өрөөнд эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох эмийн жагсаалтыг үйлчлүүлэгчдэд харагдахуйц газар ил байрлуулж, зайлшгүй шаардлагатай эмийн 6 дахь жагсаалт, “Эм” сэрэмжлүүлэг, “Эмийн тухай мэдээлэл” сэтгүүл, “Эмийн зохистой хэрэглээ” ба “Эмийн эмчилгээ”-ний гарын авлагуудыг бүх эмч, эмийн санч нарт хуваарилж, хүргүүлэх ажлыг зохион байгууллаа.	70
		31.Эмнэлэг, лабораторийн тоног төхөөрөмжийн байнгын нийлүүлэлт, засвар үйлчилгээг хангах тогтолцоо бий болгож, оношилгооны чадавхийг сайжруулах	Аймгийн хэмжээнд нийт 12 сумын эмнэлэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зайны оношилгооны цахим нэгдсэн сүлжээг ашигладаг болсноор Эрүүл Мэндийн Яамнаас шинэ мэдээ мэдээллийг шуурхай авч, солилцох, мэргэжилтнүүд болон эмч нар ажлын байрандаа суралцах нөхцөл бүрдлээ. Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлгийг иж бүрэн 15ш компьютероор хангаснаар цахим хэлбэрээр мэдээлэл солилцох боломж бүрдэж, Сайхан сумын Номгон тосгоны эмнэлэг “Тогтвортой амьжиргаа-2” төслөөс 4.7 сая төгрөгийн эмийн бус эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангагдлаа. “Идэвхтэй хөдөлгөөн-Эрүүл аж төрөх ёс” нэг сарын аяны хүрээнд зарим сумын эмнэлгүүдийн чийрэгжүүлэлтийн кабинетыг тохижуулах ажлыг өрнүүлж, Хүдэр, Сант, Түшиг сумд, Сайхан сумын Номгон тосгонд шинэ тоног төхөөрөмжийг суурилуулан хэмжих хэрэгслүүдийг байршуулснаар эмчилгээ, оношлогооны чанарыг сайжруулж, иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүллээ. “Өрхийн амьжиргааг дэмжих-2” хөтөлбөрийн 2.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Түнхэл тосгоны эмнэлэг шүдний зөөврийн машинаар хангагдаж, Орон нутгийн 20.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлэгийн эмийн бус эмчилгээ, лаборатори, төрөх, мэс заслын тасгуудад их засварын ажил хийгдэж, таатай орчин бүрдлээ.	100
<b>4.6. Соёл, урлагийн хөгжлийн бодлого</b>				
13	<b>Бүх үе шат (2007-2021 он):</b> Үндэсний соёлыг эрчимтэй хөгжүүлэх эдийн засаг, зохион байгуулалтын орчинг бүрдүүлнэ:	32.Соёлын удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт зах зээлийн эдийн засгийн горимд шилжих үйл явцыг түргэтгэж, салбарын бүх шатанд мэргэжлийн ба удирдлагын үр чадварыг дээшлүүлэх;	Соёлын ажилтны өдрийг тохиолдуулан аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй соёлын төвийн эрхлэгч нарын сургалт, соёлын байгууллагын удирдлагуудын уулзалт, туршлага судлах арга хэмжээг зохион байгууллаа. Соёл урлагийн байгууллагуудын бүтэц, бүрэлдэхүүн, удирдлагын арга барил, ур чадварыг дээшлүүлэх, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, уран бүтээл, урын санг баяжуулах, уран бүтээлчдийн ур чадварыг дээшлүүлэх, аймаг, улс, олон улсын хэмжээнд зохиогдож буй соёл урлагийн наадам, уралдаан тэмцээнд оролцох, аймгаа сурталчлах, үзвэр үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, ажлын орчин нөхцлийг сайжруулахад анхаарч ажилласны үр дүнд соёл урлагийн нийт ажилтанд мэргэжилтэй ажилтны эзлэх хувь 70.2, 2010 онд мэргэжил дээшлүүлсэн ажилтны эзлэх хувь 17.02-т тус тус хүрсэн байна.	100

			<p>Мэргэжлийн урлагийн байгууллагууд үндэсний болон олон улсын хэмжээнд томоохон ач холбогдолтой бүтээл, туурвил, арга хэмжээг зохион байгуулах, гадаад харилцаагаа өргөжүүлэх, хүн ам руу чиглэсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлэхэд анхаарч, Төрийн соёрхолт, ардын уран зохиолч Б. Лхагвасүрэнгийн зохиол “Буур хээрийн домог” бүжгэн жүжгийг Ардын дуу бүжгийн “Сэлэнгийн долгио” чуулгад тавьж, Үндэсний дуу бүжгийн эрдмийн театрын найруулагч, зураачтай хамтран ажиллалаа. Аймгийн хэмжээгээр 16 уран бүтээлч Хөгжим бүжгийн коллеж, Соёлын дээд сургууль, СУИС-д суралцаж байна. Ардын дуу бүжгийн “Сэлэнгийн долгио” чуулгын нийт уран бүтээлчдийг ажлын байранд нь Төрийн соёрхолт, Урлагийн гавьяат зүтгэлтэн, найруулагч, бүжиг дэглээч С. Сүхбаатарын удирдлаган дор тайзны соёл, ур чадвар нэмэгдүүлэх чиглэлээр дуу бүжгийн “Мөнгөн Хараа” чуулгын 3 хөгжимчинг Хурд хамтлагийн ажлын байранд гитар хөгжим тоглох ур чадвар дээшлүүлэх сургалтанд тус тус хамрууллаа. Аймгийн хэмжээний ардын авъяастнуудын судалгааг гаргаж, СУИС, Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулга, Хөгжим бүжгийн коллеж, Морин хуурын чуулга зэрэг мэргэжлийн байгууллагуудад 10-30 хоногийн хугацаанд 20 гаруй уран бүтээлчдийн ур чадварыг дээшлүүллээ.</p>	
		<p>33. Үндэсний монгол бичгээ өвлүүлэн хөгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх</p>	<p>Орон нутгийн төрийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан хаагчдад өөрийн нэр, албан тушаал, үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний нэр, орц зэргийг монгол бичгээр бичих, монгол хэл, уран зохиолын багш нараар дамжуулан хэрэгжүүлж, хэрэглээний бичиг болгох ажлыг шат дараатайгаар зохион байгуулж, сургууль бүрт монгол хэл бичгийн кабинет байгуулан гэрчилгээтэй монгол бичгийн төрөлжсөн 16 кабинетад сургалт явуулж байна. Сургууль бүр компьютертаа монгол бичгийн фонд суулгаж, монгол бичгээр сургалтын хэрэглэгдэхүүнээ боловсруулан ашиглаж, суралцагчдын сурах идэвх, сонирхлыг өрнүүлэх зорилгоор “Хурдан уншигч”, “Хичээнгүй бичигч”, “Сайхан бичигтэн”, “Зөв бичигч”, “Монгол бичгээр нэрээ бичиж сурцгаая”, “Цэвэр бичигтэн”, “Монгол бичгийн бага олимпиадыг сурагчдын дунд зохион байгуулж, дүгнэж хэвшлээ. 2010 онд Баянгол, Цагааннуур, Сайхан сумын монгол хэл, уран зохиолын багш нар төсвийн байгууллагын 150 гаруй ажилтанд 15 удаагийн сургалтыг зохион байгуулж, 180 хүн хамрагдсан байна. <b>Монгол бичгийн хичээлийн аймгийн олимпиад, монгол бичгийн төвийн бүсийн уламжлалт 7 дугаар олимпиадыг тус тус зохион байгуулж, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Төв аймгийн ерөнхий боловсролын сургуулиудаас шалгарсан 40 сурагч, бага ангийн 17 багш оролцож, багийн нийлбэр дүнгээр Сэлэнгэ аймгийн багш сурагчид тэргүүллээ.</b> Монгол бичгийн сургалт, сурталчилгааны “Ертөнц” төвөөс зохион байгуулдаг монгол бичгийн улсын олимпиадад “Эрдмийн чуулган” сургуулийн багш С.Цэндээ 3-р байр эзэлж, хүрэл медаль, Алтанбулаг сумын сургуулийн багш Б.Анхбаяр, Сүхбаатар сумын 4-р сургуулийн багш А.Эрдэнэтуяа, Сүхбаатар сумын 1-р сургуулийн сурагч Г.Бадамнямбуу нар амжилттай оролцлоо. Түүх нийгмийн ухааны багш нар</p>	<p>100</p>

			түүхийн эх сурвалжийг монгол бичгээр уншиж сургалтандаа ашиглан, монгол хэл бичгийн багш нартай хамтран монгол хэл бичгийн болон түүх нийгмийн ухааны хичээлийн 200 гаруй сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулж, уралдаан тэмцээнийг хамтран зохион байгуулж, “Боловсрол суваг” телевизээр аймгийн шилдэг багш нарын монгол бичгийн анхан болон дунд шатны хичээлийг нэвтрүүлээ.	
<b>4.8. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн бодлого</b>				
14	<b>Бүх үе шат (2007-2021 он):</b> Гэр бүл, нийгэм, хамт олонд тулгуурласан халамжийн тогтолцоог төлөвшүүлж, халамжийн үйлчилгээг олон улсын жишигт хүргэж хөгжүүлнэ:	34.Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдийн хэрэгцээ, сонголтод түшиглэсэн халамжийн олон талт үйлчилгээг бий болгож, үйлчилгээг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотойгоор хүргэх тогтолцоог бүрдүүлэх;	2009-2010 онд халамжийн үйлчилгээнд хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудыг татан оролцуулах ажлын хүрээнд “Гэмтэл согог сэргээн засах төв”-өөр 3 иргэнд 6.0 сая төгрөгийн протезийн хөнгөлөлт, “Эрхэм чанар” төрийн бус байгууллагаар 4 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 1100.0 мянган төгрөгийн протез хөнгөлөлт, “Тахир дутуу иргэдийн сэргээн засах үндэсний төв”-өөр 6 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 2.9 сая төгрөгийн протез, “ЭМЖЖ” чих хамар хоолойн эмнэлгээр сонсголын бууралттай 78 ахмад настанд 41.0 сая төгрөгийн, хөгжлийн бэрхшээлтэй 33 иргэнд 18.9 сая төгрөгийн ортопедийн хөнгөлөлт, “Тарни”, “Ноён тур”, “Бэрх”, “Сонгино” амралтанд 191 ахмадад 10917.1 мянган төгрөгийн хөнгөлөлт үйлчилгээ үзүүлээ.	100
		35.Хөдөөгийн хүн амд зориулсан нийгмийн явуулын үйлчилгээг хөгжүүлэх	2009-2010 онд аймгийн “Нээлттэй хаалганы өдөр”-өөр 1866 иргэнд нийгмийн даатгалын хуулийн талаар заавар зөвлөгөө өгч, 57 иргэний тэтгэврийн талаарх асуудлыг газар дээр нь шийдвэрлэж ажиллалаа. Хөдөлмөр халамжийн үйлчилгээгээр Мандал, Баянгол, Сайхан, Орхонтуул, Баруунбүрэн, Сант, Орхон, сум, Хэрх, Түнхэл, Номгон, Рашаант тосгонд явуулын үйлчилгээ үзүүлж, 437 иргэнд хөдөлмөр эрхлэлтийн болон нийгмийн халамжийн тухай хуулийн талаар зөвлөгөө өгч, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөнгөлөлт үйлчилгээнд хамруулж ажиллалаа.	100
15	Нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно:	36.Олон давхаргат болон олон сонголтот тэтгэврийн тогтолцоо бүрдүүлэх;	Засгийн газраас хөдөлмөрийн насны иргэн бүрийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон, суурь даатгал үүсгэн заавал даатгуулагч нарын нийгмийн даатгалын санд ажил олгогч даатгуулагчаас төлсөн шимтгэлийг хуримтлуулан олон сонголтот тэтгэврийн тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээ нь төслийн шатанд явагдаж байна.	10
		37.Хуулийн этгээдэд ажиллаж байгаа хүн бүр нийгмийн даатгалд заавал хамрагдах зарчимд шилжих;	2010 оны жилийн эцсийн байдлаар 954 иргэнийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулж 68,9 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд орууллаа. Эрүүл мэндийн даатгалд малчин, албан бус секторт хөдөлмөр эрхлэгч, ажилгүй иргэд, жижиг аж ахуй эрхлэгч 3311 иргэнийг хамруулж, 50.6 сая төгрөгийг эрүүл мэндийн санд орууллаа.	100
<b>ТАВ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>				
<b>5.1.1. Улсын төсвийн бодлого</b>				
16	Төсвийн төлөвлөлтийг	38.Төсвийг төсвийн	2009-2010 онуудад аймгийн эдийн засаг, төсөв санхүүгийн чадавхийг	100



	<p>Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэхэд нийцүүлэн боловсронгуй болгоно:</p>	<p>байгууллагуудын бодит хэрэгцээнд нь нийцүүлэн төлөвлөж, санхүүжүүлэх;</p>	<p>нэмэгдүүлэн орон нутаг өөрийгөө санхүүжүүлэх зорилт тавин, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулж төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг боловсронгуй болгон урсгал зардлыг хэмнэх, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа. Монгол Улсын төсвийн тухай хуулиудыг үндэслэн орон нутгийн төсвийн орлогын нөөц боломжинд тулгуурлан төсвийн орлого, зарлагын урьд оны гүйцэтгэлийг үндэслэн бодит хэрэгцээнд нийцүүлэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүнээр буюу хөтөлбөрт суурилсан төсөвлөлтийн зарчмаар орон нутгийн төсвийн төслийг боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, батлагдсан төсвийн хүрээнд зарлага санхүүжилтийг хийж гүйцэтгэсэн. Үүнд 2009-2010 онд 25.8 сая төгрөгийн орлогыг аймгийн төсөвт төвлөрүүлж, орон нутгийн төсвийн байгууллагуудад 16143.4 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийгдсэнээс хөрөнгө оруулалтанд 5302.5 сая төгрөг зарцуулж, 8535.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүллээ.</p>	
		<p>39.Төсвийн ил тод байдлыг хангах.</p>	<p>Тайлант хугацаанд төлөвлөлтийг боловсронгуй болгон, орлогын боломжит эх үүсвэрүүдийг бүрэн дайчлах, татварын тогтвортой орчинг бий болгосноор эдийн засаг, төсөв санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх, төсвийг зориулалтын зүйлд зарцуулах, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа. Төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтыг төсвийн байгууллагуудаас татан авч аймгийн Статистикийн хэлтсийн сар бүрийн мэдээлэлд дэлгэрэнгүйгээр тусгах, байгууллагын мэдээллийн самбарт тогтмол байрлуулж, иргэдэд төсвийн тухай мэдээллийг ил тод хүргэн ажиллаж байна. 2009-2010 оны орон нутгийн төсвийн орлого зарлагын төсөл, төсвийн тодотголыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж, баталсан төлөвлөгөөг орон нутгийн сонин хэвлэлд нийтэлж, аймгийн албан ёсны цахим хуудсанд байрлуулж төсвийн ил тод байдлыг бүрэн хангаж ажиллалаа.</p>	<p>100</p>
<p>17</p>	<p><b>Нэгдүгээр үе шат (2007-2015 он):</b> Уул уурхайнсалбарт байгаль орчныг хамгаалж, экологийн тэнцвэрт байдлыг хадгална:</p>	<p>40.Уул, уурхайн ашиглалтанд өртсөн талбайн нөхөн сэргээлтийг сайжруулах;</p>	<p>Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газрын хамтарсан хяналт шалгалтыг Мандал, Баянгол, Орхонтуул, Түшиг, Хүдэр, Ерөө сумд болон Бугант тосгонд зохион байгуулж илэрсэн зөрчлийг газар дээр нь шийдвэрлэх, зарим аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр зогсоох арга хэмжээ авч, шалгалтын нэгдсэн дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хулаар хэлэлцүүлээ. Үзлэг шалгалтанд нийт 30 гаруй аж ахуйн нэгж хамрагдсанаас Хүдэр сумын “Золотая корона” ХХК, “ДБТХ” ХХК, Ерөө сумын “Хунанжинлэн” ХХК, “Итгэлт хүлэг” ХХК, “Капитал гоулд майнинг” ХХК зэрэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр зогсоох арга хэмжээ авсан. 2010 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд нийт техникийн нөхөн сэргээлт 154 га, биологийн нөхөн сэргээлт 140.6 га талбайд хийгдсэн дүнтэй байна.</p>	<p>100</p>
		<p>41.Уурхайн олборлолтын технолог</p>	<p>Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан “Усан сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх</p>	

		нэгдсэн стандарт мөрдүүлэх;	<p>үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм"-ийг ашигт малтмалын ашиглалтын болон элс хайрга олборлох аж ахуйн нэгжүүдэд үйл ажиллагаандаа баримтлан ажиллах талаар зөвлөмж, чиглэл хүргүүлж, алтны уурхайнуудын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллалаа.</p> <p>"Байгаль орчны салбарын ажилтны зөвлөлгөөн"-ийг Байгаль орчин аялал жуулчлалын яамтай хамтран зохион байгуулж, аймгийн уул уурхайн салбарын өнөөгийн байдал цаашдын зорилт, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, байгаль орчинд халгүй, хөрс ус агаарт хоргүй байгаль экологид ээлтэй техник, технологи нэвтрүүлэх зэрэг сэдвээр хэлэлцүүлэг, ярилцлага өрнүүллээ. Аймгийн хууль хяналтын байгууллагуудтай хамтран Хүдэр, Ерөө, Мандал, Баянгол, Ерөө, Орхонтуул, Түшиг сумдад алт олборлогч, ус ихээр хэрэглэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд Байгаль орчныг хамгаалах багц хуулийн хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдлыг арилгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, технологийн хяналтыг тогтмолжуулаад байна. Аймгийн нутаг дэвсгэрт олборлоод орхигдсон болон уурхайн хаягдал эфель дээр хууль бусаар ашигт малтмал олборлогчдод зөвшөөрөлгүйгээр механикжсан тоног төхөөрөмж ашигласан зөрчил удаа дараа гарч байсныг таслан зогсоох талаар хугацаатай үүрэг, даалгавар өгч, хуулийн дагуу зохих арга хэмжээг авч ажиллалаа.</p>	100
		42.Хаягдал багатай, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж байгаа уурхайг урамшуулах хөшүүргийг бий болгон мөрдөх;	<p>Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Бороо гоулд, Болд төмөр Ерөө гол зэрэг уурхайн байгууллагууд орчин үеийн техник, технологийг үйл ажиллагаандаа бүрэн ашиглаж улс, аймгийн ашигт малтмал олборлох үйлдвэрлэлийн үнэмлэхүй хувийг эзэлж байна.</p> <p>Аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын зүгээс дээрх байгууллагуудыг бодлогын хэмжээнд дэмжин ажиллаж аймгийн Засаг даргын 2009 оны 243 тоот "Журам шинэчилж батлах тухай" захирамжийн дагуу жижиг дунд үйлдвэр, өрхийн үйлдвэрлэл, бизнес эрхлэх замаар ажилгүйдэл ядуурлыг бууруулахад амжилт гаргасан сум, аж ахуйн нэгж, иргэдээс "Шилдэг аж ахуйн нэгж"-ээр Ерөө сумын "Болд төмөр Ерөө гол" ХХК-ийг шалгаруулж, өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулсан.</p>	100
18	<b>Нэгдүгээр үе шат (2007-2015 он):</b> Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ:	43.Жижиг, дунд үйлдвэрлэлд санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай	<p>2009-2010 онд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Засгийн газрын болон аймгийн "Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан"-гаас 3.5 тэрбум төгрөгийг 175 иргэн, аж ахуйн нэгжид олгож 616 ажлын байрыг бий болгоод байна. Үүний үр дүнд аймгийн хэмжээнд шинээр 2 гурилын үйлдвэр, талх нарийн боовны 4 цех, барилгын материалын 2 үйлдвэр, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн боловсруулах 3 үйлдвэр ашиглалтанд орж, 74 иргэн аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Жижиг дунд үйлдвэрлэлийн борлуулалтын орлого 978.8 сая төгрөгт хүрч, 3087.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 6.3 хувиар нэмэгдэж, аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн борлуулалтын 0.9 хувьтай тэнцэж байна.</p>	100
		44.Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж, бага оврын	<p>Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулан аймгийн "Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан"-гаас зөвхөн тоног төхөөрөмжинд зээл олгох шийдвэр гарган 3 жилийн хугацаатай хүүгүй зээлийг олгож байна.</p>	100

		тоног төхөөрөмжийн лизингийн үйлчилгээг өргөжүүлэх.	Аймгийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас банкны баталгаагүй иргэдийн 41 төсөлд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх, өргөтгөхөд зориулан 762.0 сая төгрөгийн хөнгөлттэй зээлийг олголоо.	
19	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлдэг төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай болгоно:	45.Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, тэдэнд техник, технологийн сонголт хийхэд нь туслах, төсөл боловсруулах, шалгаруулах явцад нь зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий төвүүдийг аймаг, нийслэл, сум, дүүргүүдэд зохион байгуулж ажиллуулах;	Сэлэнгэ аймаг дахь Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран 17 сумын үйлдвэрлэл, хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтнүүдэд олон улсын төсөл хөтөлбөрт хамруулах арга зам сэдэвт сургалтыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Бүсийн төвүүдэд бизнес мэдээллийн төв байгуулах ажлыг эхлүүлж, Мандал суманд жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдэд мэдээ, мэдээллээр хангах зорилгоор бизнес мэдээллийн төвийг байгуулахад аймгийн Засаг даргын зүгээс 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн үйл ажиллагааг нь эхлүүлсэн. Тус төв нь үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш нийтдээ 30 гаруй иргэдэд мэдээлэл, зөвлөгөөгөөр үйлчилсэн байна.	100
		46.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу олгогдож байгаа тусгай зөвшөөрлийг цахим үйлчилгээнд бүрэн шилжүүлэх.	“Бизнесийн орчны шинэтгэлийн жил”-ийн хүрээнд дэвшүүлсэн зорилтыг хангаж, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Монгол Улсын ерөнхий сайдын захирамжийн дагуу аймгийн хэмжээнд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн судалгааг гарган хүргүүлээ. Аймгийн хэмжээнд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд нийт 31 зөвшөөрөлд тодорхойлолт, дүгнэлт гаргаж өгсөн байна.	70
<b>5.2.1.4. Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн хөгжлийн бодлого</b>				
20	<b>Нэгдүгээр үе шат (2007 – 2015 он):</b> Бүс нутгийн онцлогыг харгалзан бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, халдварт өвчний гаралт, тархалтыг эрс бууруулан малыг эрүүлжүүлж, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалт, экспортыг нэмэгдүүлнэ:	47.Монгол малын тэсвэрт чанарыг бататган, цус ойртохоос урьдчилан сэргийлж, биологийн боломжийг бүрэн ашиглаж, байгалийн эрсдэл даах чадварыг нь бэхжүүлэх;	Хээлтүүлэгч малыг сум, багийн хооронд солих, зохиомол хээлтүүлэг хийх, тэжээлийн төрөл, чанарыг сайжруулах замаар монгол малын тэсвэрт чанарыг дээшлүүлэх, төрлийн нийлүүлгээс сэргийлэх, байгалийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан. Тайлант онд 1101 үнээ, 1383 эм хонинд зохиомол хээлтүүлэг хийж, 1785 хээлтүүлэгч малыг сум баг хооронд солих арга хэмжээг зохион байгуулж малын тэсвэрт чанарыг сайжруулах, цус ойртохоос урьдчилан сэргийлэх, байгалийн эрсдэл даах чадварыг нь бэхжүүлэхэд анхааран ажиллаж байна.	100
		48.Малын чанар, үржлийн ажлыг сайжруулах	Алтанбулаг, Цагааннуур, Сайхан, Түшиг, Хушаат, Хүдэр, Сант, Зүүнбүрэн суманд үхрийн, Орхон, Ерөө, Баянгол, Хүдэр, Цагааннуур суманд хонины зохиомол хээлтүүлгийн цэг ажиллуулж байна. Тайлант онд 1101 үнээ, 1383 хонинд зохиомол хээлтүүлэг хийлээ. 2009 онд зохиомол хээлтүүлэг хийсэн 1077 үнээнээс 86 хувь нь, хонины 1100 эх малаас 87 хувийн үр дүнтэй гарсан. Мах, сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй байгуулахаар ирүүлсэн 4 төсөлд 89.0 сая төгрөгийн зээлийг олголоо. Эрчимсэн мал аж ахуйн хөгжлийг	100

			дэмжих хөтөлбөрөөс Цагааннуур сумын “Тариан Цацал” ХХК–д 20.0 сая төгрөгийн зээл олгож, хагас суурин маллагаатай фермерийн аж ахуйн тоо 130 болж, өмнөх оныхоос 18-аар нэмэгдсэн байна.	
		49.Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, сайжруулах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх замаар багтаамж, даацыг нэмэгдүүлэн мал аж ахуйн эрсдэлийг бууруулах;	Суурин болон хагас суурин мал аж ахуй эрхлэх, эрчимжүүлэх талаар “Бэлчээр ашиглалтыг сайжруулах тухай” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол гаргуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Бэлчээрийг улирлаар хуваарьтай ашиглах, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, хашиж, хамгаалах, ашиглалтаас түр хугацаагаар чөлөөлөх чиглэлээр гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрийн байгууллагатай хамтран сургалтуудыг зохион байгуулан ажиллаж байна. “Тогтвортой амжиргаа 2” төсөлтэй хамтран жил бүр “Бэлчээр, эрсдэлийн менежментийн төлөвлөлт, загвар үйл ажиллагаа, эрсдэлийг даван туулах арга хэмжээний төлөвлөлт” сэдэвт сургалтыг зохион байгуулж, холбогдох мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл, 17 сумын хөдөө аж ахуйн мэргэжилтэн, газрын даамлуудыг хамруулж байна. Бэлчээрийг зүй зохистой ашиглах, талхагдал, доройтлоос сэргийлэх, ургамлын нөхөн төлжих нөхцлийг бүрдүүлэх зорилгоор “Бэлчээрийн тухай” хуулийн төсөлд санал өгч Мянганы сорилтын сангийн “Хот орчмын бэлчээр”-ийн төсөлд 11 сумын 97 малчны бүлэг 76.8 мянган га бэлчээрийг эзэмшүүлэхээр шийдвэрлэж, гэрээ байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлээд байна.	70
21	Газар ашиглалтыг сайжруулж, усалгаатай тариаланг хөгжүүлэн, биотехнологи нэвтрүүлэн газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ:	50.Услалтын оновчтой системийг бий болгон усалгаатай газар тариалангийн техник, тоног төхөөрөмжийг лизингээр олгох, усжуулалтын барилга байгууламжийн эзэмшилт, ашиглалтыг зах зээлийн зарчимд нийцүүлж сайжруулах;	Услалтын сиситемийг засварлах шинээр барьж байгуулах тендерт Баруунбүрэн, Орхон, Хүдэр, Мандал, Хушаат, Сүхбаатар, Алтанбулаг, Жавхлант, Баянгол, Сант сумдын 9 аж ахуй нэгж, 8 иргэн оролцож, Баруунбүрэн сумын “Жаргалант баянбүрд” ХХК, Хушаат сумын “Монголын хөдөөг шинэчлэхийн төлөөх фермерийн холбоо” Цагааннуур сумын “Их жаргалант уул” ХХК, Хүдэр сумын “Арвин бэлчир” ХХК, “Урсгал Хүдэр” ХХК, Зүүнбүрэн сумын “Миний ээж” ХХК, Сүхбаатар сумын иргэн Ж.Цэрэндорж, Мандал сумын Б.Болормаа, Баруунбүрэн сумын И.Баасанжав нар шалгарч 419.0 сая төгрөгийн санхүүжилт авснаар 472 га талбайг услах боломжийг бүрдүүлсэн. Мөн Ерөө, Хүдэр, Хушаат, Орхон, Баруунбүрэн, Мандал сумдад усалгаатай тариалан эрхлэх талбайн хайгуулын судалгааг хийгээд байна. 2009-2010 онд усалгаатай тариалан эрхлэх 10 аж ахуйн нэгж, 7 иргэн, тендерт шалгарч 2.9 тэр бум төгрөгийн дэмжлэг авч ашиглалтад оруулсан байна. Аймгийн дүнгээр усалгаатай тариалангийн хэмжээ 2008 онд 5882 га, 2009 онд 7807 га, 2010 онд 8936 га-д хүрч 2009 оныхоос 14.4 хувь, 2008 оныхоос 51.9 хувиар тус тус нэмэгдүүллээ. Усалгаатай тариалангийн хэмжээ нэмэгдсэнээр нэгж талбайгаас үр тариа 35.8 цн, төмс 252.5 цн, хүнсний ногоо 185.2 цн-ийг тус тус хураан авч байна.	100
		51.Богино хугацаанд түргэн боловсордог чанартай үрийг өргөн хэрэглэж, таримал ургамлын нэр төрлийг олшруулах;	2009 оноос хэрэгжүүлсэн сортын бодлогын хүрээнд Дарханы УГТСЭШХ-ийн эрдэмтдийн гаргасан дархан 74 сортыг үржүүлэх арга хэмжээг зохион байгуулж 2010 онд 600 тн үрийг тариалалтанд ашиглалаа. 2009 онд нийт 140715 га-д тариалалт хийснээс арвай 470 га, овъёос 334 га, гурвалжин будаа 10 га, бог будаа 40 га, тэжээлийн ургамал 175 га, техникийн ургамал 2743 га-д тус тус тариалж 822 тн арвай, 206 тн овъёос, 39 тн гурвалжин	100

		<p>будаа, 16 тн бог будаа, 412 тн тэжээлийн ургамал, 3062 тн техникийн ургамал тус тус хураан авсан байна.</p> <p>2010 онд нийт 143895.6 га тариалснаас үр тариа 129575.2 га үүнээс буудай 125250.7 га, арвай 3063.4 га, овъёос 1206.2 га, гурвалжин будаа 5 га, бог будаа 50 га, тэжээлийн ургамал 1485.2 га үүнээс царгас 377.0 га, эрдэнэшиш 392.9 га, наранцэцэг 70.3 га, шар буурцаг 426 га бусад ургамал 182 га, техникийн ургамал 12835.1 га-д тариалсан нь 2009 оныхоос арвайн тариалалт 6 дахин, овъёос 2,7 дахин нэмэгдсэн. Сагад будааны "Татьяна" сортын үрийг нутагшуулах зорилгоор Зүүнбүрэн, Шаамар суманд 15 га-д тариалж 50 гаруй тн будаа хураан авч иргэдэд нийлүүллээ. 2010 онд 450 га-д эрдэнэ шиш, наранцэцгийн ургамал тариалж 1840 тн ургац бэлтгэж, богино болцтой арвай 3063,4 га-д, овъёос 1206 га-д бог будаа 50 га-д тус тус тариалснаар таримал ургамлын нэр төрөл олширч байна. Овьёос, арвайн сортуудыг туршин энэ онд нийт 3000 гаруй га талбайд тариаллаа.</p>	
	52.Жимс, жимсний мод үржүүлгийн газруудыг байгуулж, жимс, жимсгэний тариалалтыг өргөтгөх;	<p>"Чацаргана" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдсан "Чацарганы суулгац зээлээр олгож" төслийн шалгаруулалтанд аймгаас 18 аж ахуйн нэгж, иргэн шалгарч 50.0 мянга гаруй чацаргана, үхрийн нүдний суулгац, Мандал, Ерөө, Алтанбулаг, Сүхбаатар, Жавхлант, Зүүнбүрэн сумын жимс, жимсгэний аж ахуй эрхлэгч 9 аж ахуй нэгжид 100.0 сая төгрөгийн зээлийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр тус тус олгож жимс жимсгэний тариалалтыг дэмжих бодлого баримтлан ажиллаж байна. Чацарганы суулгац зээлээр олгох төслөөс 8 сумын 8 аж ахуй нэгж, 3 иргэнд нийт 17.0 мянган суулгац олгож, нийт 119.1 га талбайд чацаргана тариалж, жимс, жимсгэнэ өмнөх оноос <b>205.9</b> хувиар өссөн байна.</p>	100
	53.Таримал ургамлын өвчин, хортонтой тэмцэх, сорт, сорилтын чанарыг сайжруулж, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх;	<p>Аймгийн хэмжээний тариалалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдээс хор, бордооны захиалгыг авч, 33 аж ахуйн нэгжид 157.7 кг алмазис, 44 аж ахуйн нэгжид 9980 литр 2.4 D бутелийн эфир, 15 аж ахуйн нэгжид 3280 литр пумасупер олгож, 2010 онд нийтдээ 120.0 мянган га талбайд химийн аргаар хог ургамалтай тэмцэх ажил хийгдэж, өмнөх оныхоос 8.5 хувиар нэмэгдсэн байна.</p> <p>Улаанбатар хотын "Нийслэл хүнс трейд" ХХК-тай хамтран Алтанбулаг, Шаамар, Сүхбаатар сумдад нийт 10 хүлэмжийг иргэдэд гэрээний үндсэн дээр олгож, өргөст хэмх тариалуулах ажлыг зохион байгуулж хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэлийн хэмжээ өнгөрсөн оныхоос 1200 метр квадратаар нэмэгдэж 8.9 тн ургац хураан авлаа. 2010 онд 43 хүлэмжийг иргэд аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй нөхцлөөр олгож 10.8 мянган метр квадрат бүхий 94 хүлэмжинд 40-өөд төрлийн 44.5 тн хүнсний ногоо хураан авч зах зээлд нийлүүлсэн байна.</p>	100
	54.Ганд тэсвэртэй үр, нутагшсан сортын үрийн талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх.	<p>Улаан буудайн сайн чанарын үрийг сайжруулах зорилгоор ОХУ-ын "Алтайская- 99" сортын 300 тн үрийг 13 аж ахуйн нэгж , "Алтайская-100" сортын 385.1 тн үрийг 15 аж ахуйн нэгж, "Алтайская-530" сортын 101 тн үрийг 8 аж ахуйн нэгж, импортын 202.7 тн үрийг 7 аж ахуйн нэгж, дотоодын 260.5 тонн үрийг 6 аж ахуйн нэгжид олгуулж 2500 тн үрийг Мандал сумын Хэрх</p>	

			тосгон, Орхонтуул, Цайдам, Сүхбаатар дахь Улсын нөөцийн цэгүүдэд стандартын дагуу бэлтгэж нийлүүллээ. Мөн 13 сумын 27 аж ахуй нэгжид 22 ширхэг 100тн-ын үрийн агуулах, 20 ширхэг үр цэвэрлэгээний САД-10 машин, ОВС-25 15 ширхэг, ЗПС-100 8 ширхэгийг олгосон. 2011 оны тариалалтанд шаардагдах үрийн 66.6 хувийг аж ахуй нэгж, иргэд нөөцөлсөн дүнтэй байна.	100
22	Газар тариалангийн болон бэлчээрийн усан хангамжийг сайжруулж, хөдөөгийн хүн амын ундны усны хэрэгцээ, шаардлагад тохирсон усны нөөцийг нэмэгдүүлнэ:	55.Ашиглагдахгүй байгаа бэлчээрийг худаг гаргаж, хурын ус хуримтлуулж, булаг шандны усыг нэмэгдүүлж, усжуулах;	Бэлчээрийн даац хэтэрсэнтэй холбогдуулан алсын бэлчээрт худаг гаргах бодлого баримталж, жил бүр аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд ус хуримтлуулах, булаг шандыг хамгаалах талаар тодорхой ажил төлөвлөн гүйцэтгэлд хяналт тавьж аймгийн хэмжээнд 30 гаруй булаг шандын усыг хамгаалалтанд авсан. 2009-2010 онд бэлчээр усжуулах чиглэлээр 114 худаг, үүнээс 54 инженерийн худгийг “Тогтвортой амжиргаа-2” төслийн санхүүжилтээр болон иргэн аж ахуйн нэгжийн хөрөнгөөр гаргаж, 79 худгийг засварлаж, шинэ худаг гаргаснаар 138.0 мянган га бэлчээр усжуулагдлаа.	100
		56.Малчдын ундны усны хүрэлцээг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах;	Засгийн газрын “Ус” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, усны талаар төрөөс баримтлах бодлогыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор аймгийн “Ус” хөтөлбөрийг батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах алслагдсан бэлчээрийн нөөцийг ашиглах зорилгоор бэлчээрт шинээр уст цэг гаргах тендерийг мэргэжлийн байгууллагын дунд зарлаж, гүйцэтгэгчээр Сэлэнгэ аймгийн “Сэлэнгэ Баян Бүрд” ХХК-ийг шалгаруулж 8 худаг гаргаж, ашиглагч, эзэмшигчид нь хүлээгэн өгсөнөөр малчдын ундны усны хүрэлцээг нэмэгдүүллээ.	100
23	Малын тэжээлийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлж, тэжээлийн шимт чанар, тэжээллэг байдлыг сайжруулах, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:	57.“Тэжээл” хөтөлбөр хэрэгжүүлж, малын тэжээл, усны хангамжийг сайжруулах;	“Малын тэжээл” аймгийн хөтөлбөрийг боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймгийн Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас тэжээлийн үйлдвэр байгуулах төсөлд 30.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. “Малын тэжээл” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Баянгол сумын “Түмэн бут” ХХК-нд 1.5 тн, Жавхлант сумын “Өгөөж андууд” ХХК-д 3.5 тн овъёос, Сүхбаатар сумын иргэн Б.Жамаа, Алтанбулаг сумын “Буман хангай” ХХК-д тус бүр 50 кг царгасны үрийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгож, овъёос 50 тн, царгас 20 тн нийт 70 тн ургац хураан авсан.	100
		58.Бэлчээрийн мал аж ахуйн эрсдэл даах чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор жилийн тодорхой хугацаанд малаа тэжээдэг малчдын арга ажиллагааг дэмжин хөгжүүлэх.	Сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд бэлчээр ашиглалтын асуудлыг тусган хэрэгжүүлснээр 2010 онд аймгийн хэмжээнд 1630.0 мян га газар бэлчээрийн зориулалтаар ашиглаж, аймгийн хэмжээнд зун намрын улиралд 40.7 мянган га бэлчээрийг сэлгэсэн, талхлагдаж доройтсон 29.8 мянган га бэлчээрийг өнжөөсөн, ашиглалтгүй байгаа 21.0 мянган га бэлчээрийг ашиглалтанд оруулсан дүнтэй байна. “Тогтвортой амжиргаа-2” төслийн санхүүжилтээр сумдын хөдөө аж ахуйн мэргэжилтэн, газрын даамал, байгаль орчны байцаагч, аймгийн газрын харилцаа хот байгуулалтын газар,ХХААЖДҮГ-ын холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулсан сургалтыг бэлчээрийг төлөвлөх ашиглалтыг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан.	70

24	Хөрсийг эвдрэлээс хамгаалах, үржил шимийг хадгалах, чийгийн ууршилтыг багасгахад чиглэсэн дэвшилтэт технологийг газар тариаланд нэвтрүүлнэ:	59.Химийн аргаар боловсруулах уриншийн хэмжээг нэмэгдүүлэх;	2009 онд химийн аргаар 35.5 мянган га талбайг бэлтгэж 2008 оныхоос 15 хувиар нэмэгдүүллээ. 2010 онд 145 мянга га талбайд уринш хийхээс 54.8 мянган га химийн уринш бэлтгэсэн байна.	100
		60.Дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд шаардлагатай хөдөө аж ахуйн машин, техникийг худалдан авахад аж ахуйн нэгж, фермерүүдэд төрөөс дэмжлэг үзүүлэх;	Засгийн газрын хөнгөлөлттэй нөхцлөөр “Белорус 1221” трактор 6, мөн Ерөө, Цагааннуур, Зүүнбүрэн сумын компаниуд өөрсдийн хөрөнгөөр Америк, Канадын 350 морины хүчтэй зүтгэх хүчний трактор 5-ыг хөрс боловсруулах техниктэй нь хамт авч техникийн шинэчлэлийг хийсэн байна. Мөн цаашид техникгүй иргэдэд үйлчлэх хүрээг өргөжүүлэх техникийн хангамжийг нэмэгдүүлэх, шинэчлэлийг үргэлжлүүлэх зорилгоор АНУ-ын “КАТ” фирмийн техник авахаар төсөл боловсруулан хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхээр ажиллаж байна. Дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд шаардлагатай хөдөө аж ахуйн машин, техникийг худалдан авахад аж ахуйн нэгж, фермерүүдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “КАТ” фирмийн техникүүд нь засварын үйлчилгээ нь хамтдаа бөгөөд жилийн 10.5 хувийн хүүтэй, барьцаа хөрөнгө шаардахгүй, 5 жилийн хугацаатай олгохоор саналыг аваад байна. “КАТ” нь 300 морины хүчтэй иж бүрэн 3 трактор, 450 морины хүчтэй 3 комбайн зэргээс бүрдэж байгаа бөгөөд энэхүү техник нь орж ирснээр 8-10.0 мянган га талбайг боловсруулах техникийн хангамжаар нэмэгдүүлэх юм.	100
		61.Тариалангийн талбайг сүрлэн хучлагатай болгож хашаалан хамгаалах;	Цаг агаарын өөрчлөлтөд тохирсон агротехнологийг нэвтрүүлэх бодлогыг баримтлан уринш бэлтгэх явцад талбайн гадаргууг хучлагатай байлгах арга техникийг нэвтрүүлж байна. Тариалангийн талбайг сүрлэн хучлагатай байлгах зорилгоор сүрэл хэрчигчээр нийтдээ 56 комбайныг тоноглож 20 гаруй мянган га талбайг сүрлэн хучлагатай болгох арга хэмжээг авлаа.	100
25	<b>Хоёрдугаар үе шат (2016-2021он):</b> Биотехнологийг нэвтрүүлж, малын үүлдэрлэг чанарыг сайжруулан, тарималын ургацыг нэмэгдүүлнэ:	62.Усалгаатай газар тариалангийн орчин үеийн технологийг өргөн нэвтрүүлж, га-аас авах ургацыг нэмэгдүүлэх	2010 онд үр тариа 4123 га, төмс 2791 га, хүнсний ногоо 1645 га тариалалт хийснээр нийт 8559.5 га-д усалгаатай тариалж, усалгаатай тариалангийн хэмжээ 2008 онд 5882 га, 2009 онд 7807 га, 2010 онд 8936 га-д хүрч 2009 оныхоос 14.4 хувь, 2008 оныхоос 51.9 хувиар тус тус өслөө. Усалгаатай тариалангийн хэмжээ нэмэгдсэнээр усалгаатай нэгж талбайгаас үр тариа 35.8 цн, төмс 252.5 цн, хүнсний ногоо 185.2 цн-ийг тус тус хураан авсан.	100
		63.Малчдын түлш, эрчим хүчний хангамжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	Малчин өрх бүрийг радио, цахилгааны эх үүсвэртэй болгох арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлж байгаа бөгөөд одоо нийт малчин өрхийн 69.8 хувь нь цахилгаан гэрэлтэй 61.1 хувь нь телевиз, радиотой, 39.0 хувь нь тээврийн хэрэгсэлтэй болсон байна.	100
26	Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээний бүх хүрээнд эрүүл ахуй, ариун цэврийн зохистой орчин бүрдүүлж, хүн амыг аюулгүй, хүрэлцээтэй хүнс тэжээлээр хангана:	64.Хүн амын эрэлт хэрэгцээнд тулгуурлан өндөр технологи бүхий хүнсний жижиг, дунд үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэн, экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг	Хүн амын хүнсний хэрэгцээг эрүүл ахуйн шаардлага хангасан дотоодын үйлдвэрлэлийн мах, сүү, гурил, төмс, гол нэрийн хүнсний ногоогоор хангах зорилгоор “Хүнсний баталгаат байдал” аймгийн хөтөлбөрийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Бага, дунд хүчин чадал бүхий талх, нарийн боов, мал нядлах, мах, сүү, хүнсний ногоо боловсруулах үйлдвэрийг нэмэгдүүлэх зорилгоор 2010 онд аймаг хөгжүүлэх сангаас 11 аж ахуй нэгж, иргэдэд 258.0 сая төгрөг, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас 5 аж ахуй нэгж, иргэдэд 30.0 сая төгрөг	100

		хангаж, экспортыг нэмэгдүүлэх;	буюу хүнсний боловсруулах үйлдвэр байгуулахад зориулан нийт 288.0 сая төгрөгийг олгосноор тэдгээрийн хүчин чадал 20 хувиар, үйлдвэрлэлтийн хэмжээ өмнөх оныхоос 15 хувиар, үйлдвэрийн аргаар боловсруулсан мах 3.3, сүү 3.6 хувиар тус тус нэмэгдсэн байна.	
<b>5.2.1.5. Аялал жуулчлалын хөгжлийн бодлого</b>				
27	<b>Нэгдүгээр үе шат (2007 – 2015 он):</b> Жуулчин тээвэрлэх болон жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлж, аялал жуулчлалын гол бүс нутгийн зам харилцаа, холбоо, эрчим хүчний хангамжийг сайжруулна:	65.Аялал жуулчлалын гол бүс нутгуудын зам, харилцаа холбоо, эрчим хүчний хангамжийг сайжруулах ажлыг бусад салбарын хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлэх.	Сэлэнгэ аймаг нийгэм-эдийн засаг, түүх соёл, байгаль, экологийн нөөц, боломжийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх замаар аялал жуулчлалыг эдийн засгийн үр ашигтай, бие даасан салбар болгон хөгжүүлэх, аялал жуулчлалын үйл ажиллагааг дэмжих бодлогыг тусгасан“Аймгийн аялал жуулчлалын зөвлөх байгуулах”, “Аялал жуулчлалын сан байгуулах”, “Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт зочлох үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаа эрхлэх журам” зэрэг бодлогын баримт бичгүүдийг боловсруулан ажилласан. Мөн аймгийн байгалийн үзэсгэлэнт, түүх соёлын дурсгалт газруудын судалгааг үндэслэн аймгийн аялал жуулчлалын маршрутыг тодорхойлж, маршрутанд зочлох үйлчилгээний байгууллага, авто замын сүлжээ, физик газар зүйн хэв шинж, байгалийн үзэсгэлэнт, түүх соёлын дурсгалт газруудыг тусган оруулсан бөгөөд судалгааны материалуудыг түшиглэн аймгийн аялал жуулчлалын газрын зургийг хэвлүүлэхэд бэлэн болгоод байна.	90
<b>5.3. Дэд бүтцийн хөгжлийн бодлого</b>				
28	Төмөр замын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулна:	66.Төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээ байгуулах асуудлыг ашигт малтмалын орд газруудыг ашиглалтанд оруулахтай холбон оновчтой төлөвлөж, хэрэгжүүлж эхлэх.	Аймгийн хэмжээнд алт олборлох аж ахуйн нэгжүүдийн гэрээний загварыг шинэчлэн, олборлолтын ажил эхлэхийн өмнө газрын төлбөр, ус ашигласны төлбөрийг барагдуулах, газрын нэгдсэн сангийн тайланд тусгах, нөхөн сэргээлтийг гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг нэг бүрчлэн гүйцэтгүүлж зөвшөөрлийг олгож хэвшлээ. 2009-2010 онд Дулаанхан-Ерөө-Төмөртэй чиглэлд 98 км төмөр зам тавих ажилд ажиллах ажилчдыг орон нутгаас гаргах гэрээний дагуу 80 гаруй ажилчдыг түр ажлын байраар ханган ажиллаж, угсралтыг бүрэн дуусч улсын комиссоор хүлээн авч байнгын ашиглалтанд оруулаад байна.	100
29	Сум, суурин газрын болон малчдын цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжруулна:	67.Төвлөрсөн системд холбогдоогүй сум, суурин газруудыг цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбохын зэрэгцээ сэргээгдэх эрчим хүч болон бусад эхүүсвэрүүдийг ашиглан байнгын цахилгаанаар хангах;	Шаамар сумын “Нарсан сүүл” гэдэг газарт 100 кв-ын хүчин чадалтай агаарын дэд өртөө, 3.8 км урттай 10кв-ын агаарын цахилгаан дамжуулах шугам, 80м урт 0.4кв хоёр гаргалгаатай шон барих ажлыг хийж гүйцэтгэлээ. Аймгийн нийт өрхүүд эрчим хүчээр бүрэн хангагдсан. Хүдэр, Шаамар, Хушаат сум, Түнхэл тосгоны цахилгаан эрчим хүчний доголдлыг арилгаж, хүчидлийг тэнцвэржүүлэх нэмэгдэл трансформатор тавих угсралтын ажлуудыг бүрэн хийж дуусгалаа.	100
		68.“ <b>Буман нарны гэрэл</b> ” хөтөлбөрийн хүрээнд бүх малчин айл өрхийг нар, салхины	“Буман нарны гэрэл” хөтөлбөрийн хүрээнд аймгийн нийт малчин айл өрхийн 80 гаруй хувь нь нар, салхины эрчим хүчний эх үүсвэртэй болж, аймгийн малчин айл өрхүүд эрчим хүчээр бүрэн хангагдсан.	100



		эрчим хүчний эх үүсвэртэй болгох;		
30	Мэдээлэл харилцааны технологийн ололтыг нийгэм, эдийн засгийн бүх салбарт өргөн нэвтрүүлнэ:	69.Зайн эмчилгээ, зайн эмнэлгийн анхдагч тусламж, үйлчилгээг үзүүлдэг болгож, нарийн мэргэжлийн эмч нар зайнаас зөвлөгөө өгөх, мэргэжлийн тусламж үзүүлэх боломжийг бүрдүүлэх;	Эрүүл Мэндийн Яамны хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлгийг иж бүрэн 15 ш компьютероор хангаж, ЭМЯ-тай холбогдох программын холболт хийж цахим хэлбэрээр мэдээлэл солилцох бүрэн боломж бүрдлээ. Аймгийн хэмжээнд нийт 17 сум 4 тосгоны эмнэлэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зайны оношлогооны цахим нэгдсэн сүлжээг ашигладаг болсноор шинэ мэдээ, мэдээллийг шуурхай авч, солилцох, мэргэжилтнүүд болон эмч нар ажлын байрандаа суралцах нөхцөл бүрдлээ. Аймгийн Нэгдсэн Эмнэлэг нь Зүрх судас, эх нярайн зайн оношлогооны кабинетууд ЭНЭШТөв, болон клиникийн нэгдсэн 3-р эмнэлэгт нийт 24 удаа дамжуулалт хийн зөвлөгөө авч, холбогдох арга хэмжээг авч ажилласан. Зүрх судасны алсын зайн оношлогооны кабинет нь сумдын эмнэлгүүдтэй 15 удаа холбогдож, зүрх судасны эмгэгийн талаарх зөвлөгөө өгсөн байна.	100
		70.Хөдөө орон нутагт утасгүй холбооны системийг эрчимтэй хөгжүүлж, 2015 он гэхэд үүрэн телефоны шинэ үеийн үйлчилгээг газрын суурь сүлжээг ашиглан хүн амын 60 хүртэл хувьд хүргэж, газар нутгийн 50 хүртэл хувийг зөвхөн газрын суурь сүлжээний тусламжтайгаар хамруулах.	Сүхбаатар, Алтанбулаг, Мандал, Баянгол, Ерөө, Баруунбүрэн, Сайхан сумд, Бугант тосгон тоон технологид бүрэн шилжиж, холбооны найдвартай ажиллагаа хангагдаж, интернет хэрэглэх боломжтой боллоо. Аймгийн хэмжээнд 4 үүрэн холбооны операторууд үйлчилгээ үзүүлж байна. Тоон технологид шилжсэн сумдын холбооны найдвартай ажиллагааг хангахад хяналт тавин ажиллалаа.	100
<b>5.3.5. Хот байгуулалт, барилгын хөгжлийн бодлого</b>				
31	<b>Бүх үе шат (2007-2021 он):</b> Хүн амын орон сууцны хангамжийг эрс сайжруулна. <b>“Орон сууц” үндэсний хөтөлбөр</b> хэрэгжүүлнэ	71.Орон сууцны шинэ хотхон, хорооллын дэд бүтцийг байгуулахад хувийн хэвшлийн оролцоог дэмжих;	2009-2010 онд аймгийн төр захиргааны байгууллагаас тогтмол дэмжлэг үзүүлэн хамтарч ажилласнаар тайлант онд “40000 айлын орон сууц” хөтөлбөрийн хүрээнд Сүхбаатар суманд бага дунд орлоготой иргэдэд зориулсан 30 айл, төрийн албан хаагчдад зориулсан 20 айл, Хушаат, Баруунбүрэн суманд 4 айл, Баянгол суманд 8 айлын орон сууцыг барьж ашиглалтанд орууллаа. Хувийн хөрөнгө оруулалтаар Мандал суманд 18, 8, 12, 96 айлын орон сууцны барилга угсралтын ажил хийгдэж байна. Мөн Сүхбаатар суманд 16 айлын орон сууц баригдаж ашиглалтанд орж, Сайхан суманд 20 айлын орон сууц баригдаж байна.	100
		72.2021 он гэхэд айл өрхийн дийлэнхи олонхийг орон сууцтай	Баянгол суманд 8, Хушаат, Баруунбүрэн суманд тус бүр 4 айлын орон сууц баригдаж ашиглалтанд орсон. Сүхбаатар суманд 20, 30 айлын орон сууц баригдахаас 30 айлын орон сууц ашиглалтанд орж, 20 айлын орон сууцны	

		болгох.	барилгын ажил хийгдэж байна. Мөн 16 айлын орон сууц хувийн хөрөнгөөр баригдаж ашиглалтанд орсон. 2009-2010 онд аймгийн хэмжээнд эрүүл мэндийн салбарын 23, боловсрол, соёлын салбарын 74, аймгийн Засаг даргын Тамгын газрын 10 нийт 107 квотийн 47 хувь буюу 53 төрийн албан хаагч Засгийн газрын “40000 айл”-ын орон сууцны хөтөлбөрийн хүрээнд урт хугацааны бага хүүтэй зээлд хамрагдаж Улаанбаатар хот болон орон нутагт орон сууцтай болоод байна. Мөн “100000 айлын орон сууц” төслийн хүрээнд Сэлэнгэ аймагт баригдах орон сууцны захиалгын саналаа хүргүүлээд байна.	100
<b>5.4. Бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн бодлого</b>				
32	Бүс нутгуудад мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурийг тавина:	73.Улаанбаатарын дагуул хот, Замын-Үүд, Алтанбулаг, Цагааннуур зэрэг суурин газруудад <b>эдийн засгийн болон худалдааны чөлөөт бүсүүдийг</b> байгуулан ажиллуулж өндөр технологи нутагшуулах.	“Алтанбулаг худалдааны чөлөөт бүс”-ийн Захирагчийн алба нь аймгийн төв Сүхбаатар суманд байрлан үйл ажиллагаагаа явуулж байна. 2009 онд 400кв-1ш, 630кв-1ш, 160кв-2ш мөн 3км-ийн урттай 6кв-ын агаарын дэд өртөөг байгуулан, улсын комисст хүлээлгэж өглөө. Мөн 630кв-ын 2 трансформатор, 6/0.4кв-ын хаалттай дэд өртөө 1, 800м3 багтаамжтай цэвэр усны сан байгуулж, цэвэр усны эх үүсвэрт шугам тавих ажлыг эхлүүлсэн. “Алтанбулаг худалдааны чөлөөт бүс”-д баригдаж буй Усан сангийн барилга, Хилийн мэргэжлийн хяналтын барилга, Гадна усан хангамжийн гол шугам, цахилгаан хангамжийн дэд өртөө зэрэг барилга багууламжуудад гэрээний үндсэн дээр мэргэжлийн зүгээс захиалагчийн хяналтыг тавьж хамтран ажиллаж байна. Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн үйл ажиллагааг идэвхжүүлэх Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын гишүүдээс бүрдсэн чөлөөт бүсийн эдийн засгийг хөгжүүлж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх анхдугаар бага хурлыг Монгол, Буриад улсын худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран зохион байгуулж, цаашид хэрэгжүүлэх зарим асуудлуудыг тодотгон тус бага хурлаас чөлөөт бүсэд хөрөнгө оруулагчдын зөвлөлийг байгууллаа. 2009-2010 онд Алтанбулаг суманд 130 ажлын байр шинээр бий болсны 80 гаруй хувь нь чөлөөт бүсэд бий болсон байна. Чөлөөт бүсийг түшиглэн худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа иргэдээс цаашид хэрэгжүүлбэл зохих нэн шаардлагатай асуудлуудаар санал асуулга явуулахад юуны түрүүнд Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн үйл ажиллагааг жинхэнэ утгаар нь эхлүүлэх шаардлагатай байна гэж судалгаанд оролцогчдын дийлэнх олонх нь илэрхийлсэн байна. Иймээс 2 талаас хамтарсан ажлын хэсгийг байгуулан ажиллуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. 2010-2011 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар чөлөөт бүсийн бүтээн байгуулалтын ажлуудыг эрчимжүүлж зарим томоохон ажлуудыг гүйцэтгэхэд зориулж 21.4 тэрбум төгрөг батлагдаж, төлөвлөгдсөн ажлууд хийгдэж байна.	70
<b>ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО</b>				
33	<b>Бүх үе шат (2007-2021он):</b> Байгаль орчны бохирдол, доройтлыг хязгаарлан зогсооно:	74.Байгаль орчинд учруулсан хохирлын эдийн засгийн үнэлгээнд тулгуурлан нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлэх;	Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Байгаль орчинд учруулж буй хор хохирлын хэмжээг багасгах, байгаль орчныг хамгаалах багц хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалтыг уул уурхайн үйлдвэрлэл болон хайгуулийн үйл ажиллагаа явуулж буй Хүдэр, Ерөө, Баянгол, Орхонтуул, Мандал сумдад хийн илэрсэн 276 зөрчилд 22982.0 мянган төгрөгийн торгууль ноогдуулж 20259.0 мянган төгрөгийг барагдууллаа. Мөн 366653.1 мянган төгрөгийн	100

			<p>нөхөн төлбөр ноогдуулж, 29260.5 мянган төгрөгийг барагдуулсан байна. Үзлэг шалгалтын үр дүнд нийт 20 гаруй аж ахуйн нэгж хамрагдаж шаардлагатай аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох арга хэмжээ авч ажиллалаа.</p> <p>Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар Алтанбулаг сумын Дүгэрээ, Их Бага цоорхой, Цагааннуур сумын Оргих, Зүүнбүрэн сумын Цармын эрээн, Тужийн нарс зэрэг тусгай хамгаалалттай газруудад 1365 га ойжуулалт хийсэн ба амьдралт нь 75 хувьтай байна. Сүүлийн жилүүдийн Байгаль цаг уурын өөрчлөлтийн улмаас шилмүүст модны үр боргоцой ургахгүй байгаад дүгнэлт хийн байнгын талбайтай болох зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр 295 га талбайг тусгаарлах ажлыг Алтанбулаг, Шаамар зэрэг сумдад ойн эрх бүхий мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх арга хэмжээг авч ажиллалаа. Мөн мод бэлтгэх эрх бүхий аж ахуйн нэгжүүдийн хөрөнгөөр 1066 га талбайд ойжуулалт нөхөн сэргээлтийн ажил хийгдлээ.</p>	
34	Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтөд дасан зохицож, сөрөг үр дагаврыг бууруулах чадавхийг бүрдүүлж хэрэгжүүлнэ:	75.Байгаль, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицсон, тэсвэрлэх чадвар сайтай үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамлын төрлийг сонгон тариалах, шинэ төрөл, сортыг бий болгох, газар тариалангийн дэвшилтэт арга, технологи боловсруулж нэвтрүүлэх;	<p>Төмс хүнсний ногоо үр үржүүлэх зорилгоор аймаг хөгжүүлэх сангаас 400.0 сая төгрөгийг 17 сумдын ногоочдын үр үржүүлэхэд зориулж 7 сарын хугацаатай хүүгүй зээл олгосон. Мөн “Ногоон хувьсгал” хөтөлбөрийн журмаар шар манжин, шар лууван, хүрэн манжин, өргөст хэмх, хар сонгино, төл сонгино, байцааны үр, импала, витара, санта сортын төмсний үр 5 тн-ийг сумдад хуваариллаа.</p> <p>Засгийн газрын хөнгөлөлттэй нөхцлөөр “Белорус 1221” трактор 6, мөн Ерөө, Цагааннуур, Зүүнбүрэн сумын компаниуд өөрсдийн хөрөнгөөр Америк, Канадын 350 морины хүчтэй зүтгэх хүчний трактор 5-ыг хөрс боловсруулах техниктэй нь хамт авч техникийн шинэчлэлийг хийсэн байна. Мөн цаашид техникгүй иргэдэд үйлчлэх хүрээг өргөжүүлэх техникийн хангамжийг нэмэгдүүлэх, шинэчлэлийг үргэлжлүүлэх зорилгоор АНУ-ын “КАТ” фирмийн техник авахаар төсөл боловсруулан хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхээр ажиллаж байна. Дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд шаардлагатай хөдөө аж ахуйн машин, техникийг худалдан авахад аж ахуйн нэгж, фермерүүдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “КАТ” фирмийн техникүүд нь засварын үйлчилгээ нь хамтдаа бөгөөд жилийн 10.5 хувийн хүүтэй, барьцаа хөрөнгө шаардахгүй, 5 жилийн хугацаатай олгохоор саналыг аваад байна. “КАТ” нь 300 морины хүчтэй иж бүрэн 3 трактор, 450 морины хүчтэй 3 комбайн зэргээс бүрдэж байгаа бөгөөд энэхүү техник нь орж ирснээр 8-10.0 мянган га талбайг боловсруулах техникийн хангамжаар нэмэгдүүлэх юм. Үр сорт шинэчлэлийг усалгаатай тариалан эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдээр үр үржүүлэх бодлого хэрэгжүүлж, Мандал, Хушаат, Зүүнбүрэн, Цагаануур, Алтанбулаг сумдад усалгаатай талбайд төмсний болон улаан буудайн үрийг үржүүлэх, үрийн чанарыг баталгаажуулах ажлыг 2 дахь жилдээ зохион байгууллаа. 2009 оноос эхлэн хөх тариа, овъёос, арвай, хошуу будаа, сагад будааны үрийг нь хөнгөлттэй нөхцлөөр олгосноор таримлын төрөл, тоо хэмжээ нэмэгдлээ. Бурядская остистая сорт 600 тн, Бурядская-79 сорт 6000 тн, Дархан-74 сорт 2000 тн-ыг тус тус бэлтгэн үржүүлж байна. 2010 онд</p>	100

		“Алтайская” сортын 786,1 тн үрээр сортын шинэчлэлийг явууллаа. <b>Буудайн үрийг сортоор</b> нь хадгалах, үрийн цэвэршилтийн байдлыг хангах зорилгоор 2009 онд 1200 тн-ын 2 ширхэг, 2010 онд 22 тооны 2200 тн үрийн будаа хадгалах агуулахаар хангалаа. Мөн үр цэвэрлэх, сортлох, ачих зориулалтын 50 тооны техник хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлж ажиллалаа.	
	76.Бүс нутгийн бэлчээрийн даацад тохирсон малын тоо толгой, сүргийн бүтцийг бүрдүүлэх талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх;	Байгаль, цаг уурын өөрчлөлтөнд дасан зохицсон, үр ашигтай, биологийн чадамж сайтай бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна. Аймгийн хэмжээгээр сүүний чиглэлийн үхрийн 81, махны чиглэлийн үхрийн 8, мах-ноосны хонины 10, гахайны 13, шувууны 5, зөгийн 13, бүгд 130 иргэн аж ахуйн нэгж эрчимжсэн чиглэлээр фермерийн аж ахуй эрхэлж, нийт 5.9 мянган үхэр, 7.9 мянган хонь, 1000 гахай, 6.3 мянган шувуу, 1415 бүл зөгий үржүүлж байна.	100
	77.Байгаль, цаг уурын өөрчлөлтөнд дасан зохицсон, үр ашигтай, биологийн чадамж сайтай бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлэх;	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн “Сэлэнгэ аймагт эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан хослон хөгжүүлэх бүс нутаг болгох тухай” тогтоолыг хэрэгжүүлж, “Хүмүүнлэгийн үйлсэд малчид, тариаланчдын оролцоо” сэдэвт зөвлөлгөөнийг зохион байгуулж, Монгол Улсын бүх аймаг, сумын нутгийн захиргааны байгууллага, иргэдэд хандан уриалга гаргаж, аймгийн нутаг дэвсгэрийг бүхэлд нь “Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан хослон хөгжүүлэх бүс нутаг болгоход баримтлах бодлого, чиглэл”-ийг батлан хэрэгжүүлж байна. 2010 онд аймгийн малын тоо 1265584 болж урьд оныхоос 18.5 хувиар буурсан байна.	100
	78.Уур амьсгалын өөрчлөлт болон цөлжилт, тэдгээрт дасан зохицох, даван туулах арга зам, сөрөг үр дагаврыг бууруулах талаар олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, мэдлэг олгох, мэдээлэл сурталчилгааны ажлыг өргөжүүлэх.	“Цөлжилттэй тэмцэх хөтөлбөр”-ийг боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлуулан хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Хөтөлбөрийг сурталчлах зорилгоор “Цөлжилтийн эсрэг хамтдаа”, “Уур амьсгалын өөрчлөлтийг стандартаар дамжуулан зогсооно” сэдэвт сургалтыг иргэд, аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл, мэргэжлийн байгуулагуудын дунд зохион байгууллаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлж, ногоон зурвас, ус, салхины элэгдэл эвдрэлд орсон газруудад аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр хамгаалалтын зурвас байгуулах ажлыг Алтанбулаг, Баянгол, Орхон, Хушаат зэрэг сумдад эхлүүлээд байна. Мөн сумдын Засаг даргатай гэрээ байгуулан цөлжилтийг бууруулах, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, бэлчээрийг зүй зохистой даацанд тохируулан ашиглах зэрэг олон талт арга хэмжээг тусгаж, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. Нэгдсэн үндэсний байгууллагын төсөл, хөтөлбөрийн газрын санхүүжилтээр бэлчээрийг хамгаалах, энгийн аргаар нөхөн сэргээх зорилгоор Баянгол суманд “Бэлчээрийн менежмент”, Орхонтуул суманд голын ай савд ургаж байгаа бургасан шугуйг хамгаалах нөхөн, сэргээх төслийг тус тус хэрэгжүүлж байна.	70

35	Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах, нөхцөлийг бүрдүүлнэ. <b>“Ус” үндэсний хөтөлбөр</b> хэрэгжүүлнэ:	79.Гадаргын усны тодорхой хэсгийг аж ахуйн эргэлтэнд оруулан арвижуулах замаар хүн ам, үйлдвэрлэлийн усан хангамжийг шийдвэрлэх;	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан “Ус” шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд усалтын систем шинээр барьж ашиглах саналыг дэмжиж, сум орон нутгийн захиалгыг үндэслэн “Усгалтын системийг сэргээн засах, шинээр байгуулах” тендерт оролцох Хушаат сумын “Нью-кроп” ХХК, Орхон сумын “Цагаан шаргал” ХХК, Сайхан сумын “Болор хур” ХХК, Түшиг сумын “Мангирт” ХХК, Улаанбаатар хотын “Шим групп” ХХК, Хүдэр сумын “Ургац хүдэр” Цагааннуур сумын “Их жаргалант -Уул”, Хөхчин ХХК, Сэлэнгэ–тариа ХХК зэрэг 10 гаруй аж ахуйн нэгжийн /нийт 1387,0 га/ усалтын систем шинээр барих зураг төслийг хянаж, усыг зохистой ашиглах талаас нь байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гарган ажиллалаа.	100
36	Ойн нөөцийг тогтвортой ашиглаж, ой хамгаалах, нөхөн сэргээх, экологийн тэнцвэрийг хадгалах нөхцөлийг хангана:	80.Ой хамгаалах ажилд дэвшилтэт менежментийн арга хэлбэрийг нэвтрүүлж, ойн сангийн 20 хүртэлх хувийг нутгийн иргэд, нөхөрлөлд гэрээгээр эзэмшүүлэн ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх.	2010 онд аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр 10 аж ахуй нэгж, байгууллага 790 га-д, мод бэлтгэх эрх бүхий 22 аж ахуй нэгж, нөхөрлөлүүд өөрийн хөрөнгөөр 650 га талбайд, гадаадын хөрөнгө оруулалтаар 3 аж ахуй нэгж, байгууллага 300 га талбайд ойжуулалт, ойг нөхөн сэргээх ажлыг хийж гүйцэтгэлээ. Нийт 1740 га талбайд ойжуулалт, нөхөн сэргээх ажил хийсэн байна. Мөн 2008, 2009 онуудад хийсэн ой зохион байгуулалтын ажлын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, үнэлгээ дүгнэлт авсан. Үүнтэй холбоотойгоор аймгийн ойн менежмент төлөвлөгөө боловсруулах, цаашид ойн бодлого боловсруулахад ашиглах тухай тогтоол гаргуулан мөрдөн ажиллаж байна.	100
<b>ДОЛОО. ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>				
37	Төрийн институцүүдийг чадавхжуулж, төрийн үйлчилгээг ил тод, хүртээмжтэй болгох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно	81.Төрийн үйлчилгээг хүртээмжтэй, ил тод болгох	Сэлэнгэ аймгийн албан ёсны <a href="http://www.selenge.mn">www.selenge.mn</a> цахим хуудсаар аймгийн танилцуулга, нутгийн удирдлагын байгууллагын бүтэц, үйл ажиллагааны үндсэн чиглэл, орон нутгийн захиргаа, төр, төсвийн байгууллагуудын мэдээллийг байршуулан аймгаас баримталж буй бодлого шийдвэр, төсөл, хөтөлбөр, цаг үеийн мэдээ мэдээллийг тухай бүр шинэчлэн иргэдэд ил тод, нээлттэй хүргэн ажиллаж байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын нэгдсэн мэдээллийн самбарт байгууллагын эрхэм зорилго, бүтэц, бодлогын хэлтсүүдийн үндсэн чиг үүрэг, Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газрын шийдвэр, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын даргын шийдвэр, Монгол Улсын Төрийн албаны тухай хуульд заасан төрийн захиргааны албан хаагчийн тангараг, нийтлэг эрх үүргийг нийтэд нээлттэй байдлаар байршуулж, тогтмол шинэчлэн ажиллаж байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үүдний танхимд LCD дэлгэцийг байрлуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны албан хаагчдын зураг, овог нэр, албан тушаал, хариуцах асуудал, холбоо барих утас, өрөөний дугаар бүхий дэлгэрэнгүй мэдээллийг дүрсжүүлсэн богино хэмжээний видео танилцуулгыг гаргаж, иргэд, үйлчлүүлэгчдэд шуурхай хүргэх боломж нөхцлийг бүрдүүллээ. Төрийн үйлчилгээний ил тод байдлыг	100

			<p>хангах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газарт мэдээллийн нэгдсэн самбар, салбарын хууль тогтоомж, бусад эрх зүйн акт, албан тушаалтнуудын холбогдох мэдээлэл бүхий танилцуулгыг албан өрөөний гадна байрлуулж, иргэдийг шаардлагатай мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна.</p> <p>Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй, хүртээмжтэй хүргэх зорилгоор жил бүр уламжлал болгон аймгийн Засаг даргын Тамгын газар, хэлтэс албадын өргөн бүрэлдэхүүнтэйгээр сумдад аймгийн “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг зохион байгуулах ажлыг тогтмолжуулаад байна. Уг арга хэмжээг 2009 онд 9 сум, 2 тосгонд, 2010 онд 17 сум, 6 тосгонд зохион байгуулж, иргэдэд эрэлт ихтэй, аймгийн төвд байрладаг төрийн үйлчилгээг сум, орон нутагт хүрч үйлчлэх боломжийг бүрдүүлж өгсөн. Энэ арга хэмжээнд давхардсан тоогоор 2009 онд 8462, 2010 онд 26257 иргэн хамрагдаж үйлчилгээ авсан байна. Аймгийн Нээлттэй хаалганы өдөр арга хэмжээгээр нарийн мэргэжлийн эмч нарын баг ажиллаж, хөдөөгийн иргэдэд нэг дор эмнэлгийн тусламж үйлчилгээг хүртэх боломж олгодгоороо онцлогтой байдаг.</p>	
38	Хүний эрхийг баталгаатай хангана:	82.Хүний эрх, эрх чөлөөг хангахад шууд үйлчилдэг тогтолцоог төрийн эрх мэдлийн хуваарилалтыг тэнцвэржүүлэн төгөлдөржүүлэх замаар боловсронгуй болгоно;	<p>Хүний эрх, эрх чөлөөг хангахад орон нутгийн төр, захиргааны байгууллагын эрх мэдэл, үүрэг хариуцлагыг тэнцвэржүүлэх ажлыг нөхцөл байдал, боломж, гарах үр дагавартай уялдуулан аймгийн онцлогтойгоор шийдвэрлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж ирлээ. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Иргэний нийгмийн байгууллагуудын хамтарсан зөвлөлдөх хороог хоёр талын саналд тулгуурлан байгуулж, аймгийн Засаг даргын захирамжаар баталгаажуулан төлөвлөгөө, гэрээтэйгээр ажиллуулж эхэллээ. Аймгийн хэмжээнд иргэдийн эрх ашгийг хамгаалахаар эвлэлдэн нэгдсэн 35 төрийн бус байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнээс тайлант онд Улаан загалмайн нийгэмлэг, Дэлхийн зөн Олон улсын байгууллагатай хүний эрхийг хангах, хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулах, Үйлдвэрчний эвлэлийн холбоотой хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн эрх зүйн сургалт, сурталчилгаа явуулах, Авлигатай тэмцэх төрийн бус байгууллагын сүлжээтэй авлига, хүнд сурталтай тэмцэх зэрэг төрөл чиглэлүүдээр аймгийн Засаг даргаас гэрээ байгуулан төрийн тодорхой зарим үүргүүдийг хариуцуулан ажиллуулж үр дүнг тооцон ажиллаж байна.</p> <p>Аймаг суманд тухайн шатны Засаг даргаар ахлуулсан Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн салбар хороодыг үйл ажиллагааны журамтайгаар 2005 онд зохион байгуулж тайлант онд бүтэц, бүрэлдэхүүнийг шинэчиллээ. Сэлэнгэ аймагт Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг 2006-2010 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 124 ажил арга хэмжээтэйгээр төлөвлөж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж хэрэгжилтийг ханган ажилласнаар төлөвлөгөө 94.8 хувьтай хэрэгжиж дууссан. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг Сэлэнгэ аймагт хэрэгжүүлэх 2011-2014 оны төлөвлөгөөний төслийг боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг</p>	100

		<p>эхлүүлээд байна. 2010 онд ХЭХҮХ-ий аймагт хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг шинэчлэхтэй холбогдуулж хүний эрхийн төлөв байдал, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар 11 сум, 2 тосгоны иргэдийн дунд санал асуулгын хуудсаар судалгаа явуулж нэгтгэн дүгнэж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралд мэдээлэл оруулсан. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор хүүхдийн эрхийг хангах, тэдгээрийг гэмт хэргээс хамгаалах, гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн эрхийг хангах, нийгэмшүүлэх чиг үүрэг бүхий аймгийн “Хүүхдийн хууль зүйн хороо”-г 17 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж үйл ажиллагааны дүрмийг баталлаа. Тайлант 2010 онд тус хороо 6 бүлгийн 28 ажил төлөвлөж бүрэн хэрэгжүүллээ.</p>	
	83.Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах;	<p>Аймгийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах үүднээс аймгийн нутаг дэвсгэрт “Цөлжилттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай”, “Сэлэнгэ-цэвэр орчин”, “Ус” зэрэг аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймгийн нутаг дэвсгэр, төв сууринг хог хаягдлаас салгах бодлого явуулж сарын аян зохион байгуулах, төв суурин газрын хогийн төвлөрсөн цэгийг цөөрүүлэх, дахин боловсруулах, хог хаягдал зайлуулах менежментийг сайжруулах, зориулалтын машин техникээр шинэчилж болон шинээр хангах ажил, арга хэмжээнүүдийг авч ажиллалаа. Мөн Үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран хөдөлмөрийн эрүүл ахуйн сарын аяныг 2009 онд тодорхой удирдамжтайгаар аймгийн хэмжээнд зохион байгуулж үр дүнг тооцож ажилласан. Хөрс, ус, агаарын шинжилгээг сар улирлаар төв, суурин бүрээр хийлгэж иргэд, олон нийтэд мэдээлэх ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж хэвшүүлж байна. 2010 онд аймгийн хэмжээнд “Хүнсний аюулгүй байдал”, “Эмийн чанар-Аюулгүй байдал”, “Эрүүл хүнс” сарын аянуудыг мэргэжлийн байгууллагууд хамтран зохион байгуулж, аян тус бүрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан бүрэн хэрэгжүүлж ажилласан. Аяны үр дүнд хүнсний болон эмийн худалдаа, үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуй нэгжүүдэд хүнсний эрүүл ахуй, эмийн чанар аюулгүй байдлын талаар хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулах, худалдаа үйлчилгээний чанарыг сайжруулах талаар зөвлөмж, шаардагыг тавьж, иргэд олон нийтийг шаардлагатай мэдээллээр хангах арга хэмжээг авч ажиллалаа.</p>	100
	84.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг тусгайлан хангах;	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх, сурах, эмнэлэг, нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангах бодлогыг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний холбооны аймгийн салбар болон аймаг дахь төрийн үйлчилгээний холбогдох байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлж байна. Энэ бодлогын хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрхийг ханган 2009 онд 331, 2010 онд <span style="background-color: yellow;">          </span> иргэнийг холбогдох хуулийн дагуу шинээр ажлын байраар хангасны дээр 2009 онд 15 иргэнд ажил үйлчилгээ эрхлэхэд дэмжлэг үзүүлж аймгийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас 17.8 сая, 2010 онд <span style="background-color: yellow;">          </span> иргэнд аймгийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих</p>	100

			<p>сангаас ,,,,,, сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгууллаа. Сайхан, Мандал суманд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор өдөрлөг сурталчилгаа, үзэсгэлэн яармаг, ажилд зуучлах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж, 120 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамрагдсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай дансанд 12376.8 мянган төгрөгийг төвлөрүүлэн ажиллалаа.</p>	
		<p>85.Хүүхдийн эрхийг хангах эрх зүйн орчинг сайжруулах.</p>	<p>Аймгийн Хүүхдийн төлөө хэлтэс, хөдөлмөр эрхлэлтийн байгууллага хамтран хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий “Найзтайгаа хамт” өдөрлөг, “Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийн эсрэг өдөр”-ийг жил бүр тэмдэглэн өнгөрүүлдэг хэвшил тогтоосон. Аймгийн хэмжээнд насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа явуулахад мал малладаг 30, уул уурхай /хувиараа алт олборлодог/ 15, мод зүсвэрийн газар үртэс зөөдөг 25, банз зөөдөг 15, бараа хүнсний зах дээр тэрэг түрдэг 9, газар тариалангийн салбарт ногоо усалж, зэрлэг зулгаадаг 25 нийт 149 хүүхдийн судалгаа гарсан. Эдгээр хүүхдүүдээс нэн ядуу амьдралтай өрхийн 26 хүүхэд хөдөлмөр эрхэлж сургууль завсардсаныг аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүүхдийн төлөө хэлтэс, Дэлхийн зөн Олон улсын байгууллагатай хамтран “Хүнд нөхцөл дэх хүүхэд” хөтөлбөрт 18 хүүхдийг хамруулан ерөнхий боловсролын сургуульд суралцуулж, халамжийн үйлчилгээнд байнгын болон түр хэлбэрээр хамруулж байна. Аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд 149, /үүнээс эмэгтэй 47/, хурдан морь унадаг 662 хүүхдүүдийн эрхийг хамгаалах үүднээс холбогдох байгууллагын ажилтнууд Монгол даатгал, Түшиг даатгал зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж 100 хувь ослын даатгалд хамруулах арга хэмжээг авч ажиллалаа.</p> <p>Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан “Халамж” 7 хоногийн нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж, 120 хүүхдийг хамрууллаа. “Хүнд нөхцөлд дэх хүүхэд” хөтөлбөрийн санхүүжилтээр байгуулагдсан “Залуус” фермер төвөөр дамжуулан хүүхдүүдэд гэр бүлийн орчинд өсч хүмүүжих, амьдрах ухааны чадварт суралцуулах, хүүхэд хамгааллын цогц үйлчилгээг үзүүлж, 2 га талбайд хүнсний ногоо тариалж, олон нийтийг түшиглэн нийгэмшүүлэх, нийгмийн харилцаанд орох чадварыг нь дээшлүүлэх арга хэмжээнүүдийг авч ажиллалаа. Эмзэг бүлгийн өрхөд амьдарч буй хүүхдүүдийг гэмт хэрэг зөрчилд орохоос урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх, хүүхэд гэр бүлийг амьдрах ухаанд сургах зорилгоор “Өөрөө өөртөө тусалъя”, “Бидний оролцоо”, “Гэр бүл хүүхэд” сэдэвт сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагын төсөл, хөтөлбөртэй хамтран зохион байгуулж нийт 26 хүүхэд хамрагдлаа. Монгол дахь Энхтайвны корпусын хүүхэд хөгжлийн хөтөлбөрийн сайн дурын ажилтантай хамтран албан бус боловсролын “Гэгээрэл” төвийн ахлах ангийн сурагчдын дунд амьдрах ухааны чадварууд цуврал номыг ашиглан хүүхдийн нас, бие, сэтгэхүйн онцлогт тохируулан оролцооны аргаар амьдрах ухааны зөв дадал, сэтгэл зүйд нь эерэг, үнэн зөв ойлголтыг төлөвшүүлэх 36 цагийн сургалтыг зохион байгуулж, 20 хүүхдийг хамрууллаа. Хүүхэд хамгааллын чиглэлээр нийт 600</p>	<p>100</p>



			хүнд зөвлөгөө, үйлчилгээ үзүүлж, сургалтанд хамруулан эрхийг нь хамгаалж ажиллалаа.	
39	Улс төрийн тогтолцоог боловсронгуй болгож, ардчилалыг гүнзгийрүүлэн хөгжүүлнэ:	86.Эдийн засгийн шинж чанартай шийдвэр гаргах шатанд хувийн хэвшлийн оролцоог хангаж, хувийн хэвшлийг дэмжих эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх;	<p>“Төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагаа” сэдэвт төрийн болон иргэний нийгэм, хувийн хэвшлийн удирдлагууд, иргэдийн төлөөлөл бүхий нийт 500-аад хүнийг хамруулсан нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж, Орчны тохижилт, газар эзэмших, өмчлөх асуудал, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн арга хэмжээг угтан зохион байгуулах ажил, арга хэмжээ гэсэн дэд сэдвүүдийг хөндөж, иргэдээс урьдчилан авсан санал асуулгад тулгуурлан харилцан санал солилцох хэлбэрээр явууллаа. Нийт оролцогчид өөрсдийн санал, бодлыг шууд болон бичгээр илэрхийлж, иргэдийг хүртээмжтэй оролцуулах зорилгоор орон нутгийн телевизүүдээр шууд дамжуулж утсаар санал авах ажлыг зохион байгуулж 2010 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүллээ.</p> <p>Мөн аймгийн “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээний үеэр аймгийн Засаг дарга нийт сумдын иргэдтэй уулзалт зохион байгуулж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч ажил хэрэг болох санал, санаачлагыг бодого шийдвэртээ тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд олон нийтийг хамарсан идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж бүх талаар дэмжиж төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бодлогыг дэмжин ажиллаж байна. Аймгийн Уяачдын, Үндэсний бөхийн, Сурын болон шагайн бусад төрлийн спортын холбоод, Улаан загалмайн хороо, Ажил олгогч эздийн холбоо, Аймгийн үйлдвэрчний эвлэлийн холбоо, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, Авлигаас урьдчилан сэргийлэх сүлжээ, Зүүний хүчний холбоо, Шинэ гэгээ, Сэлэнгийн мэдээ, Таны Сэлэнгэ, Миний Монгол, Залуус, Хараа зэрэг хэвлэл мэдээллийн болон олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, 2009-2010 онд 51.4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, ажлын үр дүнг тооцож ажиллалаа.</p> <p>Төрийн бус байгууллага, иргэний нийгмийн төлөөлөлтэй хамтран ажиллах оновчтой санал, санаачлагыг дэмжиж хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор хамтран ажиллах гэрээ, зөвлөлдөх хорооны бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журмыг боловсруулж батлан хэрэгжүүлж байна.</p>	100
		87.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тогтолцоог боловсронгуй болгох замаар тоог нь цөөн, шат дамжлагыг нь цомхон болгож, иргэдэд үзүүлэх үйлчилгээг чанаржуулах.	<p>Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн, Засаг даргын дэргэдэх зарим агентлагуудыг шинэ бүтцээр зохион байгуулалтанд оруулж үйл ажиллагааг нь жигдрүүлж төрийн ажил, үйлчилгээний хэвийн байдлыг хангуулан ажиллаж байна.</p> <p>Сумдын Засаг даргын Тамгын газрын бүтцийг тухайн нутаг дэвсгэрийн онцлог, хүн амын суурьшилаас нь хамаарч 14-25 хүртэлх орон тоотойгоор баталж, урд өмнө байсан ажлын хийдэл, давхардлыг арилгах, төрийн албан хаагчдын ажил үүргийн хуваарийг тэнцвэржүүлэх, ачааллыг жигдрүүлэх зорилгоор Төрийн захиргаа хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн зэрэг зарим орон тоог шинээр баталж</p>	100

			<p>өгсөн.</p> <p>Монгол Улсын Засгийн газраас баталсан “Монго мал” хөтөлбөрийн хүрээнд сумдын Засаг даргын Тамгын газарт Хөдөө аж ахуйн тасаг байгуулагдсантай холбогдуулан нийт 51 төрийн захиргааны албан хаагчдыг томилон ажиллуулж эхлээд байна.</p>	
40	<p>Засаг захиргаа, нутаг дэвсгэрийг эдийн засгийн чадамж, хүн амын нөөцөд тулгуурлан томсгоно:</p>	<p>88.Баг, хороог төрийн үйлчилгээг иргэдэд хүргэдэг төрийн захиргааны хамгийн анхан шатны нэгжийнх нь хувьд бэхжүүлэх;</p>	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газраас Орхонтуул сумын Шар Усны 1-р багийг тосгоны статустай болгох тухай асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдаанд оруулж тус багийг “Рашаант” тосгон болгохоор шийдвэрлүүлж, тосгоны захирагчийн албаны бүтэц орон тоог батлан үйл ажиллагааг эхлүүлсэн.</p> <p>Хүн амын суурьшил ихтэй, нэг багт ноогдох өрх, хүн амын тоо олонтой байдлаас шалтгаалан багийн иргэдэд хүрч үйлчлэх, төрийн бодлого шийдвэрийг сурталчлах ажилд ихээхэн хүндрэл учирч байсан бодит байдлыг харгалзан Мандал суманд 4 баг, Сүхбаатар суманд 3 багийг шинээр нэмж байгуулах асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүллээ. Ингэснээр нэг багт дундажаар 3000 орчим иргэд ноогдож багийн ажлын ачаалал харьцангуй жигдэрч иргэдэд шуурхай үйлчлэх боломж нь бүрдэх юм.</p> <p>Засаг захиргааны анхан шатны нэгж болох багийг чадавхжуулах, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор сумын Засаг даргын Тамгын газрын дарга, багийн Засаг дарга нарын нэгдсэн сургалт семинарыг зохион байгуулж, багуудын ажиллах нөхцлийг сайжруулах зорилгоор Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран 6 тосгон, 56 багийг шаардлагатай компьютер, принтер, бусад техник хэрэгслээр хангаад байна.</p>	100
41	<p>Төрийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэтгэж, бодитой, үнэмшилтэй цахим мэдээллийн тогтолцоо, сан байгуулна:</p>	<p>89.Иргэний баримт бичгийг цахимжуулах;</p>	<p>Аймгийн Засаг даргын 2009 оны “Бүтэц орон тоо батлах тухай” 52 захирамжаар сумдад иргэний бүртгэлийн ажилтны ажлын байр бий болгож иргэний бүртгэлийн ажил үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх нөхцлийг бүрдүүлсэн. Хүн амын улсын бүртгэлийн нэгдсэн сантай аймгийн иргэний бүртгэлийн мэдээллийн санг онлайн сүлжээгээр холбож мэдээллийг хурдан шуурхай солилцдог болгосон.</p> <p>Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоо бий болж, бүртгэлийн байгууллагын орон нутгийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсний дагуу 2009 оны сүүлийн хагасаас иргэний бүртгэл мэдээллийн ажил, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий Улсын бүртгэлийн хэлтсийг Иргэний бүртгэлийн, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн, Хуулийн этгээдийн бүртгэлийн тасагтай нийтдээ 30 орчим ажилтантайгаар ажиллуулж үйл ажиллагааг нь жигдрүүлсэн.</p> <p>Шинэчлэн зохион байгуулагдсан Улсын бүртгэлийн хэлтсийг нутгийн захиргааны 2-р байранд 2 танхим, архив, техник хэрэгсэлийн иж бүрэн тоног төхөөрөмжтэйгөөр шилжүүлж төвлөрүүлэн үйлчилгээний ая тухтай нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээ авсан. Аймгийн Засаг даргаас 2010 онд Иргэний баримтын зөрчил арилгах зарим арга хэмжээний тухай 49 тоот захирамж, 5 тоот албан даалгаваруудыг тус тус гаргаж ажиллан нийт 91263 иргэнийг хамруулан 5631 зөрчлийг илрүүлэн шийдвэрлэж, аймгийн хэмжээнд иргэний</p>	100

			шинэчилсэн бүртгэлийн ажлыг явуулж хамрагдвал зохих 70980 иргэнээс 60842 иргэнийг, 16-аас доош насны 29222 хүүхдээс 20754 хүүхдийг тус тус хамруулан бүртгэлийн ажлыг амжилттай зохион байгуулж ажилласан.	
		90.Нийслэл, аймгийн төв, томоохон суурин газрын хаягийн бүртгэлийг шинэчлэн, шифр, кодын нэгдсэн тогтолцоог улсын хэмжээнд бий болгож, олон улсын жишигт хүрсэн хаягжуулалт, газар усны нэр, хаягийн нэгдсэн сантай болох;	Аймаг, сумын төвийн суурин газрын айл өрх, гудамж талбайн хаягийг шинэчлэн бүртгэж, орон нутгийн болон хот хоорондын зам дагуух газар усны нэрийг байршуулах ажлыг нэгдсэн журмаар зохион байгуулах ажлыг 2007 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр хаягийн байршлыг тодорхойлох, газар, усны нэрийг зөв хэрэглэх нөхцөл бүрдлээ. 2011 онд аймгийн 80 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан ойд бэлтгэх ажлын хүрээнд төлөвлөгөө гарган, сум орон нутгийн зам, газар усны нэр хаягийг шинэчлэх ажлыг тусгайлан оруулж, холбогдох албан тушаалтнуудыг үүрэгжүүлэн хэрэгжүүлж эхлээд байна.	70
42	Төрийн албаны бодлого, дүн шинжилгээний болон төрийн албан хаагчийн манлайллын чадамжийг шинэ түвшинд хүргэнэ:	91.Төрийн албаны удирдах албан тушаалтан, ялангуяа ерөнхий менежерийг нээлттэй өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулах.	2009-2010 онд төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтанд аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс, Эрүүл мэндийн газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар, Хушаат, Жавхлант, Ерөө, Түшиг, Хүдэр сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, Хушаат, Зүүнбүрэн, Хүдэр Орхонтуул сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга нарын албан тушаалын сонгон шалгаруулалтыг аймгийн “Сэлэнгийн мэдээ” сонин, мэдээллийн хэрэгслээр нийтэд нээлттэй байдлаар зарлан 7 удаа 13 албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохих хууль, журмын дагуу зохион байгуулан явуулж, үр дүнг хэрэгжүүлж ажиллалаа. Аймгийн Боловсрол соёлын газраас 11 цэцэрлэг, 2 сургуулийн захирлын албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохион байгуулан нийт 27 хүн хамрагдаж хамгийн өндөр оноо авч тухайн ажлын байрны ерөнхий шаардлагыг хангасан 13 хүнийг томилуулан ажиллуулж байна.	100
43	Байгууллагын болон хүний нөөцийн хөгжлийг хангана:	92.Дотоод шийдвэр нь ил тод, ажлын гүйцэтгэлд чиглэсэн суралцагч байгууллагыг хөгжүүлэх;	Төрийн албан хаагчийн сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааг аймгийн хэмжээнд зохион байгуулан нийт 73 төр төсвийн байгууллагын албан хаагчдыг хамруулснаас 2575 төрийн албан хаагчдын 73 хувь нь ямар нэг төрлийн сургалтанд хамрагдах хэрэгцээтэй байгаа нь тодорхойлогдсон. Иймээс төрийн албаны өөрчлөлт, шинэчлэлтийн өнөөгийн чиг хандлагаар мэдлэг чадвартай мэргэшсэн төрийн албан хаагчдаар иргэдэд чанар, хүртээмжтэй төрийн үйлчилгээг үзүүлэх шаардлагыг үндэслэн “Төрийн албан хаагчийн мэдлэг чадвар” хөтөлбөрийг боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулан хэрэгжүүлж эхлээд байна. Хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргын 2010 оны 110 тоот захирамжаар тухайн онд зохион байгуулах сургалт, семинар, зөвлөгөөний нэгдсэн хуваарийг батлан хэрэгжүүлж ажилласнаар нийт 26 зөвлөгөөн, 25 сургалт семинар, 25 спортын уралдаан тэмцээн, 16 бага хурал, үзэсгэлэн худалдаа, уулзалт зэрэг нийт 89 ажил арга хэмжээнд давхардсан тоогоор 1200 гаруй төрийн албан хаагч, иргэд оролцлоо.	100

		<p>2009-2010 онд Удирдлагын академийн төрийн удирдлагын магистрийн сургалтанд 4, төрийн болон нийгмийн удирдлагаар мэргэшүүлэх менежерийн сургалтанд 11, богино хугацааны зорилтот сургалтанд 24, харъяалах дээд байгууллагын төлөвлөгөөт 182 удаагийн сургалтанд 892, нийт зохион байгуулагдсан сургалт семинарт давхардсан тоогоор 2566 төрийн албан хаагч хамрагдсан байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын нийт ажилтнуудын аппаратын зөвлөлгөөнөөр хүний нөөцийн зорилтын хүрсэн түвшинг баталгаажуулах, тогтвортой ахиулах, сул тал, алдаа дутагдлыг засаж залруулах, дахин давтахгүй байх талаар байгууллагын дотоод асуудлыг нээлттэй хэлэлцэж, Тамгын газрын “Дотоод журам”-ыг шинэчлэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Тус зөвлөгөөний үр дүнд ажилтнуудын ажиллах таатай орчныг бүрдүүлэх арга хэмжээ авч, гарсан саналыг үндэслэн харилцан мэдээлэл солилцох зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын “Мэдээллийн цаг” арга хэмжээг байгуулж эхэлсэн нь ажилтнуудын хэрэгцээнд нийцсэн арга хэмжээ болж, үйл ажиллагаанд бодитой үр дүнгээ өгч байна. Мөн мэдээллийн цагийн арга хэмжээг нутгийн захиргааны бүх шатны байгууллагуудад нэвтрүүлж, нийт сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд долоо хоногийн 1 өдөр байгууллагын шуурхай хурал, сонсгол, мэдээллийн цаг хэлбэрээр зохион байгуулж хэвшээд байна.</p>	
	93.Төрийн албан хаагч бүрт хүний нөөцийн удирдлагын үр чадварыг эзэмшүүлэх.	<p>Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Шведийн Засгийн газартай хамтран Шведийн олон улсын хөгжлийн агентлаг, Шведийн төрийн захиргааны олон улсын институт байгууллагаар дамжуулан хэрэгжүүлж буй төслийн хүрээнд бэлтгэгдсэн аймгийн сургагч багш нарын орон нутгийн Манлайллын сургалтыг нийт сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албадын дарга нар, төсвийн байгууллагын ерөнхий менежерүүд, аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийг хамруулсан нийт 5 удаагийн шаталсан сургалтыг зохион байгуулсан нь төрийн албан хаагч бүрт хүний нөөцийн удирдлагын чадавхийг хөгжүүлэх, гүйцэтгэлийн менежментийг хэрэгжүүлэхэд үр дүнгээ өгч байна. Түүнчлэн шинэ оны гараан дээр нутгийн захиргааны удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж өнгөрсөн жилийнхээ ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэн шинэ оныхоо бодлогын зорилт, чиглэлээ тодорхойлж, гэрээ хэлцлээ байгууллах ажлыг тогтмолжуулаад байна.</p>	100
	94.Төрийн албаны цалин хөлсний тогтолцоог хөдөлмөрийн зах зээлийн харилцааны нөхцөлд тохируулах, ил тод болгох, гүйцэтгэл, урамшууллын оновчтой механизмтай холбох замаар боловсронгуй	<p>Сум, хэлтэс албадын үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийх журмын дагуу нутгийн захиргааны бүх байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тэргүүн, дэд, гутгаар байр эзэлсэн сум, сумын Засаг дарга, алба, хэлтэс, газрууд түүний дарга нарын шагналд 2009 онд 6356.0 мянган төгрөг, 2010 онд 15640,0, мянган төгрөг, тэргүүний хамт олон, салбарын тэргүүний ажилтны шагналд 2009 онд 2557.0 мянган төгрөг, 2010 онд 2015,0 мянган төгрөг, журмын дагуу өрхийн аж ахуйг эрхлэх замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад амжилт гарган, шинээр ажлын байр бий болгосон шилдэг сум, байгууллагын болзол хангасан</p>	100

		болгох.	байгууллагын шагналд 2009 онд 925.5 мянган төгрөг, 2010 онд 902,0, мянган төгрөгөөр тус тус урамшуулсан. 2009-2010 онд аймгийн хэмжээний нийт төрийн албан хаагчдад 32292081.1 мянган төгрөгийн цалин, нэг удаагийн буцалтгүй тусламж, тэтгэмж, урамшуулалд 1227537.6 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж буй эрүүл мэнд, боловсролын салбарын төрийн албан хаагчдад 169814.1 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчдад 588388.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон дүнтэй байна. Мөн өөрийн салбартаа олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажилласан 87 төрийн албан хаагчийг аймгийн Засаг даргын жуух, түүнийг дагалдах 1740.0 мянган төгрөгөөр урамшуулсан.	
44	Төрийн албаны оновчтой хэмжээг хангаж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ:	95.Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийх замаар төрийн албыг үе шаттайгаар цомхон чадварлаг болгож, зохистой хэмжээнд хүргэх;	Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 67 тоот тогтоолын дагуу Аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын бүтцийг аймгийн Засаг даргын 2009 оны 08 тоот захирамжаар шинэчлэн зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын Тамгын газрыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасагтай/, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хууль зүйн хэлтэс /Архивын тасагтай/, Хөгжлийн бодлогын хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Цэргийн штаб гэсэн зохион байгуулалтын 6 нэгжтэй, Засаг даргын дэргэдэх агентлагийг 20 хэлтэс, газартайгаар зохион байгуулан бүтэц, чиг үүргийг шинэчлэн ажиллаж байна. Аймгийн Засаг даргын 2009 оны 52 тоот захирамжаар сумдын Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн баталгаажуулж мөрдөн ажиллаж байна. Сум бүрт “Монгол мал” хөтөлбөрийн хүрээнд батлагдсан бүтэц орон тооны дагуу Хөдөө аж ахуйн тасгийг шинээр зохион байгуулан нийт 51 төрийн захиргааны албан хаагчийг томилон ажиллуулж байна.	100
		96.Төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчдыг намын гишүүнчлэлгүй болгож, Төрийн албаны зөвлөлийн эрх хэмжээг нэмэгдүүлж, төрийн албыг тогтворжуулж, төрийн албаны боловсон хүчний нөөцийг бүрдүүлдэг системийг бий болгож, төрийн албыг чанаржуулах.	Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь заалтын хэрэгжилтийг хангах ажлыг аймгийн хэмжээнд 2009 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдөж улс төрийн намын гишүүнчлэлээс нийт 1837 төрийн албан хаагч түтгэлзэх саналаа гарган төрийн албан тушаалыг эрхлэн ажиллаж байна. Төрийн захиргааны албан тушаалын сул орон тоог Төрийн албаны зөвлөлийн <a href="http://www.csc.gov.mn">www.csc.gov.mn</a> болон аймгийн <a href="http://www.selenge.mn">www.selenge.mn</a> цахим хуудас, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлан Төрийн албаны мэргэшлийн шалгалтанд 2009-2010 онд нийт 936 хүн хамрагдаж, төрийн жинхэнэ албаны нөөцийн жагсаалтанд нийт 392 хүн бүртгэлтэй байгаагаас 140 хүн төрийн жинхэнэ албанд томилогдсон дүнтэй байна. Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 тоот тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалын нөөц бүрдүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, төрийн захиргааны албан тушаалын сул орон тоог төрийн албаны нөөцөд бүртгэлтэй иргэдээс нөхөх арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Зарим ерөнхий менежерийн буруутай үйл ажиллагааны улмаас төрийн захиргааны албан тушаалын сул орон тоог нуун дарагдуулсан, томилгоог дур мэдэн хийсэн алдаа дутагдлыг илрүүлэн	100

			зөрчлийг арилгуулах талаар Төрийн албаны салбар зөвлөлийн шаардлага хүргүүлэн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалаа.	
<b>7.5. Гадаад бодлого</b>				
45	<b>Бүх үе шат (2007-2021 он):</b> Энхийг эрхэмлэсэн, идэвхтэй гадаад улс төрийн бодлогыг хэрэгжүүлнэ:	97.Зүүн Хойд Ази, Зүүн Азийн харилцан уялдаа бүхий хамтын ажиллагааны үйл явцыг урагшлуулах яриа хэлэлцээрт нэгдэхийг эрхэмлэж, тус бүс нутагт байр сууриа бэхжүүлэх.	6 улсын 69 засаг захиргааны нэгжийн гишүүнчлэл бүхий Зүүн Хойд Азийн Бүс Нутгийн Засаг захиргааны холбоонд Монгол Улсын Засаг захиргааны нэгжээс Сэлэнгэ аймаг анхны гишүүдийн нэгээр элсэн орж өнөөг хүртэл тус холбоо болон, холбооны Хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан арга хэмжээнүүдэд тасралтгүй идэвхтэй оролцож ирснээр аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагаа Зүүн хойд азийн бүс нутагт өөрийн гэсэн байр суурийг бэхжүүлж байна. 2009 онд Япон Улсад зохион байгуулагдсан Зүүн хойд азийн бүс нутгийн орнуудын гамшгаас хамгаалах тусгай хорооны 7-р хурал, БНХАУ-ын Хэнан мужийн Жөнжөү хотын “Аялал жуулчлалын хорооны хурал”, БНСУ-ын Кёнги мужийн Сүвон хотноо зохион байгуулагдсан “Ажлын хорооны хурал”, “Шинжлэх ухаан, технологийн хурал”, БНСУ-ын Тэгү хотын “Худалдаа эдийн засгийн хорооны хурал” зэрэг арга хэмжээнүүдэд аймгийн 9 төлөөлөгч, 2010 онд БНСУ-ын Кёнсанбуг аймгийн Кёнжү хотноо зохион байгуулагдсан ЗХАБНЗЗХ-ны гишүүн байгууллагуудын Гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хурал, БНСУ-ын Кёнсанбуг аймгийн Кёнжү хотноо зохион байгуулагдсан ЗХАБНЗЗХ-ны гишүүн байгууллагуудын “Олон улсын эдийн засгийн форум”, БНХАУ-ын Хэнан мужид зохион байгуулагдсан “Аялал жуулчлалын дэд хорооны хурал”-д нийт 12 төлөөлөгчийг оролцуулж ажил мэргэжлийн туршлага судлуулан, аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэн ажиллаж байна.	100
46	Эдийн засгийн үр ашигтай гадаад харилцааг хөгжүүлнэ:	98.Эдийн засгийн гадаад харилцааг аль болох олон талтай болгоход чиглэсэн бодлого явуулах;	Сэлэнгэ аймаг 2009 оноос эхлэн БНСУ-ын Кёнсанбуг аймгийн Бунхва сум хоорондын харилцаа, хамтын ажиллагааны гэрээний дагуу нутгийн захиргааны байгууллагын мэргэжилтэн солилцох ажлын зохион байгуулж, 2009 онд 2 ажилтан, 2010 онд мөн 2 ажилтанг 6 сарын хугацаатайгаар солилцож харилцан туршлага судлуулах арга хэмжээг авч ажиллалаа. Ингэснээр 2 талын мэргэжилтнүүдийн мэргэжлийн болон гадаад хэлний мэдлэг чадвар дээшлэх, гадаад харилцаа хамтын ажиллагаа улам бэхжих таатай нөхцөл бүрдэж байна. Хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-ын Бунхва сум тус аймгийн орлого багатай өрх, иргэдийн амьдралыг дэмжихэд зориулан бараа материалын хандив, тусламжийг үзүүлж, иргэдэд хүртээх ажил хийгдсэн. 2009 онд БНАЛАУ-ын Аттапы аймаг, ХБНГУ-ын Шлесвиг-Холштайн мужтай гадаад харилцааны шинэ түншлэлийг бий болгож, нийгэм эдийн засгийн бүхий л салбарт хамтрах, хөдөө аж ахуйн салбарт голлон ажиллахаар харилцан тохиролцлоо. 2010 оны 1 дүгээр сард Бүгд найрамдах Герман Улсад зохион байгуулагдсан “Ногоон долоо хоног” олон улсын үзэсгэлэн яармаг, хөдөө аж ахуйн сайд нарын дээд хэмжээний II-р чуулга-уулзалтанд Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай тэргүүтэй төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд аймгийн Засаг дарга хамрагдаж, уг арга	100

			<p>хэмжээний үеэр Герман Улсын Шлесвиг-Холштайн муж улс болон Сэлэнгэ аймгийн хооронд Хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах санал дэвшүүлэн улмаар “Шлесвиг Холштайн мужийн үхрийн аж ахуй” байгууллага болон “Хээлтүүлэг, үржүүлгийн институт”-д үхрийн аж ахуйн салбарт аймгийн 5 фермерыг богино хугацааны дадлага-сургалтанд хамруулахаар боллоо. Мөн тус муж улстай хамтран ажиллах санамж бичгийн төслийг боловсруулан, үзэглэхэд бэлэн болгоод байна.</p> <p>БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хоттой харилцан туршлага солилцох ажлыг зохион байгуулаад байна. Эрээн хотноо зохион байгуулагдсан “Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын эх газар хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, эдийн засгийн коридорыг бий болгоё” чуулга уулзалтанд аймгийн төлөөлөл оролцож байр сууриа илэрхийлж 3 улсын бүс нутгийн хамтын ажиллагааг дэмжих Сэлэнгэ аймгийн салбар зөвлөлийг байгуулж, ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.</p> <p>Монгол Улс дахь АНУ-ын Элчин Сайд Жонатан С.Эдлтон Сэлэнгэ аймагт танилцах айлчлал хийж, хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах саналтай байгаагаа илэрхийлэн энэ талаар АНУ-ын ЭСЯамнаас холбогдох судалгаа хийгдэж байна.</p> <p>БНХАУ-ын Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга Чо тэргүүтэй Шандунь мужийн үйлдвэрлэгчид төлөөлөгчид, БНХАУ-ын ӨМӨЗО-ны ардын төлөөлөгчдийн байнгын хорооны дарга, Намын хорооны нарийн бичгийн дарга Ху Чуньхуа тэргүүтэй төлөөлөгчид Сэлэнгэ аймагт танилцах айлчлал хийж энэ үеэр аймгийн бизнес, жижиг дунд үйлдвэр эрхлэгчидтэй хамтран ажиллахаар боллоо.</p> <p>БНСУ-ын Кёнгансбуг мужаас зохион байгуулсан “Шинэ тосгоны хөдөлгөөн” сургалтанд аймгийн төлөөлөгчдөө оролцуулж туршлага судлуллаа.</p> <p>Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын эдийн засгийн форумыг 6-р сард Сэлэнгэ аймагт зохион байгуулах бэлтгэл ажлыг бүрэн хангаад байсан боловч ОХУ-ын талаас шалтгаалан хойшлогдсон бөгөөд 9-р сарын 24-25-нд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотын дарга, Ардын Төлөөлөгчдийн Хурлын Байнгын Хорооны дарга нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчдийг аймагтаа хүлээн авч, аймгийн удирдлагуудын төлөөлөлтэй хамт ОХУ-ын Буриад улсад айлчлан БНХАУ-д эдийн засгийн форумыг зохион байгуулах талаар уулзалтыг зохион байгуулсан.</p>	
<b>7.6. Батлан хамгаалах салбарын бодлого</b>				
47	<p><b>Бүх үе шат (2007-2021 он):</b></p> <p>Орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэн бэхжүүлнэ:</p>	<p>99.Залуу үеийг эрүүлжүүлэх, өндөр боловсрол, мэдлэг, чадвар олгох, зэвсэгт хүчний байнгын болон дайчилгааны нөөц бие бүрэлдэхүүний чанарыг сайжруулах, нийт</p>	<p>Аймгийн цэргийн насны эрчүүдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулан өвчтэй гарсан иргэдийг эрүүлжүүлэх эмчилгээнд хамруулах, бичиг үсэг тайлагдаагүй залуучуудад албан бус боловсролын төвтэй хамтран сургалт явуулж бичиг үсэг заах арга хэмжээг жил бүр зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>2008-2010 онд дүйцүүлэх алба биечлэн хаасан Шаамар, Алтанбулаг, Жавхлант сумын 30 иргэн гүйцэтгэвэл зохих ажил үүргийг бүрэн биелүүлж, бэлтгэлээр халагдсан ба 2009-2011 онд зүйчүүлэх албыг биечлэн хааж байгаа Зүүнбүрэн, Сайхан сумын 30 иргэн 120-150 хоногийн ажил үүргийг</p>	90

		иргэдийн цэрэг, зэвсэгт хүчнээрээ бахархах сэтгэлгээг төлөвшүүлэх;	гүйцэтгээд байна. Цэргийн дүйцүүлэх албыг биечлэн хаах хүсэлтээ гаргасан Ерөө, Хүдэр сумын 40 иргэнийг сонгон авч 14 хоногийн сургалтанд хамруулан үүрэгт ажлын 50 хувийг гүйцэтгэсэн байна. 2009-2010 онд Зэвсэгт хүчний Жанжин штабаас захиалсан цэргийн мэргэжлийн дагуу 120 цэргийн бэлтгэл үүрэгтэнг Зэвсэгт хүчний 330, 119, 234 дүгээр ангийн сургалтын төвийг түшиглэн 14 хоногийн давтан сургалтанд хамруулснаар дайчилгааны бэлтгэл нөөц 75 хувьд хүрээд байна.	
--	--	--	---	--

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГЫН  
СЭЛЭНГЭ АЙМАГТ ХАМААРАЛТАЙ ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ДҮНГИЙН НЭГТГЭЛ  
/2010 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/**

2011.03.11

№	Агуулга	Нийт зорилтын тоо	Үүнээс						Нийт хувь	
			100%	90%	70%	50%	30%	10%	0	2010
<b>Нэг</b>	<b>ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ХИЙГЭЭД НИЙГМИЙН ХӨГЖИЛ</b>									
1	Ядуурал, ажилгүйдлийг бууруулах бодлого	3	3							<b>100</b>
2	Жендэрийн тэгш байдлыг хангах бодлого	1	1							<b>100</b>
3	Гэр бүлийн хөгжил, хүн ам зүйн бодлого	2	2							<b>100</b>
4	Боловсролын хөгжлийн бодлого	8	8							<b>100</b>
5	Эрүүл мэндийн хөгжлийн бодлого	17	14	1	1		1			<b>93.5</b>
6	Соёл, урлагийн хөгжлийн бодлого	2	2							<b>100</b>
7	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн бодлого	4	3							<b>77.5</b>
<b>Хоёр</b>	<b>ТАВ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>									
1	Улсын төсвийн бодлого	9	8		1					<b>96.6</b>
2	Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн хөгжлийн бодлого	18	16		2					<b>96.6</b>
3	Аялал жуулчлалын хөгжлийн бодлого	1		1						<b>90</b>
4	Дэд бүтцийн хөгжлийн бодлого	5	5							<b>100</b>
5	Хот байгуулалт, барилгын хөгжлийн бодлого	2	2							<b>100</b>
6	Бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн бодлого	1			1					<b>70</b>
<b>Гурав</b>	<b>ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО</b>	7	6		1					<b>95.7</b>
<b>Дөрөв</b>	<b>ДОЛОО. ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>	16	15		1					<b>98.1</b>
1	Гадаад бодлого	2	2							<b>100</b>
2	Батлан хамгаалах салбарын бодлого	1		1						<b>90</b>
	<b>Бүгд</b>	<b>99</b>								<b>94.6</b>

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

